



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2026 оны 02 дугаар сарын 16
№07 (1402)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

26.	Журам батлах тухай	Дугаар 193	463
27.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 215	504

462

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр
сарын 16-ны өдөр

Дугаар 193

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Иргэний нисэхийн тухай хуулийн 7.1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 136 дугаар тогтоол, “Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 339 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

Засгийн газрын 2025 оны 04 дүгээр
сарын 16-ны өдрийн 193 дугаар
тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН АЮУЛГҮЙН ХАМГААЛАЛТЫН ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын журам (цаашид “журам” гэх)-ын зорилго нь Иргэний нисэхийн аюулгүй, найдвартай, үр ашигтай байдлыг хангаж, иргэний нисэхийн үйл ажиллагааг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахад оршино.

1.2.Энэ журам нь олон улс, орон нутгийн нислэгт үйлчилж байгаа нисэх буудал, дотоодын болон гадаадын агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлыг хамгаалах үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэхэд үйлчилнэ.

1.3.Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагаа нь зорчигч, агаарын хөлгийн багийн гишүүн, газрын үйлчилгээ болон хилийн хяналтын байгууллагын ажилтан, иргэн, агаарын хөлөг, нисэх буудлын байгууламж, тоног төхөөрөмжийг газарт болон агаарт тохиолдож болох хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахад чиглэгдэнэ.

1.4.Орон нутгийн нислэгийн үйл ажиллагааг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах арга хэмжээг эрх бүхий байгууллагаас хийсэн аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн үнэлгээг үндэслэн хэрэгжүүлнэ.

1.5.Энэ журам нь Олон улсын иргэний нисэхийн тухай конвенц болон түүний Хавсралт 2 (Нислэг үйлдэх журам), Хавсралт 6 (Агаарын хөлгийн ашиглалт), Хавсралт 8 (Агаарын хөлгийн нислэгт тэнцэх), Хавсралт 9 (Хялбаршуулах), Хавсралт 10 (Нисэхийн холбоо), Хавсралт 11 (Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ), Хавсралт 13 (Агаарын хөлгийн осол, сүйрлийг шинжлэн шалгах), Хавсралт 14 (Аэродром), Хавсралт 17 (Нисэхийн аюулгүйн хамгаалалт), Хавсралт 18 (Аюултай барааг агаараар аюулгүй тээвэрлэх)-д тусгасан нисэхийн аюулгүйн хамгаалалттай холбоотой олон улсын стандарт, зөвлөмжид нийцсэн байна.

1.6.Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

1.6.1.“агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр” гэж агаарын хөлгийг газарт болон агаарт тохиолдож болох хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зорилгоор зорчигч, агаарын



хөлгийн багийн гишүүн, газрын үйлчилгээний ажилтан, агаарын тээвэрлэгч, эсхүл түүний төлөөлөгчийн хэрэгжүүлэх арга хэмжээ болон үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлж, энэ журмын шаардлагад нийцүүлэн боловсруулсан баримт бичгийг;

1.6.2.“агаарын тээвэрлэгчийн шуудан болон эд зүйлс” гэж агаарын тээвэрлэгчийн дотоод үйл ажиллагаанд зориулагдсан, эсхүл гэрээт байгууллагад хүргүүлэх зорилгоор тээвэрлэх бичиг баримт, хангамжийн материал, техник үйлчилгээний сэлбэг, нислэгийн хоол хүнс, цэвэрлэгээний болон бусад эд зүйлсийг;

1.6.3.“агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалтын үзлэг” гэж сэжигтэй эд зүйлс, зэвсэг, тэсрэх бодис, бусад аюултай хэрэгсэл, эд зүйлс, бодисыг илрүүлэх зорилгоор агаарын хөлгийн дотор хийх үзлэгийг;

1.6.4.“агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалтын шалгалт” гэж сэжигтэй эд зүйлс, зэвсэг, тэсрэх бодис, бусад аюултай хэрэгсэл, эд зүйлс, бодисыг илрүүлэх зорилгоор агаарын хөлгийн дотор болон гадна хэсэгт хийх шалгалтыг;

1.6.5.“анкет шалгалт” гэж нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай болон аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх хүсэлт гаргасан этгээдийн биеийн байцаалт болон өмнөх туршлага, гэмт хэрэгт холбогдож байсан эсэх, аюулгүйн хамгаалалттай холбоотой бусад мэдээллийг шалгахыг;

1.6.6.“ачаа” гэж агаарын хөлгөөр тээвэрлэх шуудан, хангамж, дагалдах, эсхүл буруу чиглэлд тээвэрлэгдсэн тээшнээс бусад эд зүйлийг;

1.6.7.“аюулгүйн хамгаалалтын соёл” гэж иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын ажилтнуудын үйлдэл, сахилга батаар илрэх өдөр тутмын үйл ажиллагаанд хамаарах аюулгүйн хамгаалалтын хэм хэмжээ, үнэт зүйл, хандлагын цогц ойлголтыг;

1.6.8.“аюулгүйн хамгаалалттай бүс” гэж аюулгүйн хамгаалалтын хяналт бүхий нисэх буудлын аэродромын талбай, барилга байгууламж, тэдгээрийн орчныг;

1.6.9.“аюулгүйн хамгаалалтын хяналт шалгалт” гэж нисэхийн аюулгүйн хамгаалалтын тодорхой арга хэмжээний үр дүнг урьдчилан мэдэгдэх, эсхүл гэнэтийн шалгалт хийх үйл ажиллагааг;

1.6.10.“арилжааны агаарын тээвэр” гэж зорчигч, ачаа, тээш, шууданг агаарын хөлгөөр төлбөртэй тээвэрлэх үйл ажиллагааг;

1.6.11.“аюулгүйн хамгаалалтын аудит” гэж энэ журмын хэрэгжилт, үр дүнд хийх бүх талын нарийвчилсан нийцлийн шалгалтыг;

1.6.12.“аюулгүйн хамгаалалтын хяналт” гэж хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсрэх бодис, аюултай хэрэгсэл, эд зүйлс, бодисыг агаарын хөлөгт нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг;

1.6.13.“аюулгүйн үзлэг” гэж Иргэний нисэхийн тухай хуулийн 5.1.6-д заасныг;

1.6.14.“аюулгүйн хамгаалалтын сорилт” гэж хөндлөнгийн хууль бус үйлдэл хийх байдлаар нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагааг ил болон далд хэлбэрээр шалгахыг;

1.6.15.“дамжин өнгөрөх зорчигч” гэж тухайн аяллын завсрын нисэх буудалд ирсэн агаарын хөлгөөр нислэгээ цааш үргэлжлүүлэх зорчигчийг;

1.6.16.“дамжин өнгөрөх тээш” гэж тухайн аяллын завсрын нисэх буудалд ирсэн агаарын хөлгөөс буулгалгүй үргэлжлүүлэн тээвэрлэх тээшийг;

1.6.17.“дипломат ачаа тээш” гэж 1961 онд Австри Улсын Вена хотноо баталсан Дипломат харилцааны тухай болон 1963 онд баталсан Консулын харилцааны тухай конвенцын дагуу тээвэрлэх дипломат шуудан болон эд зүйлсийг;

1.6.18.“нийтийн эзэмшлийн бүс” гэж зөвшөөрөлгүйгээр чөлөөтэй нэвтэрч болох нисэх буудлын барилга байгууламж, түүний орчны хэсгийг;

1.6.19.“нислэгийн аюулгүйн хамгаалалтын ажилтан” гэж агаарын тээвэрлэгчийн харьяалах улсын Засгийн газраас эрх олгосон, эсхүл агаарын хөлгийн бүртгэлтэй улсын Засгийн газраас тухайн агаарын хөлөг, зорчигчдыг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалахаар томилсон (агаарын хөлөгт тодорхой хувь хүнийг тусгайлан хамгаалж байгаа хувийн бие хамгаалагч үүнд хамаарахгүй) этгээдийг;

1.6.20.“нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хороо” гэж нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгасан аюулгүйн хамгаалалтын хяналт болон журмын хэрэгжилтийг зохицуулахад нисэх буудалд туслах үүрэг бүхий иргэний нисэхэд үйлчилгээ үзүүлж байгаа нисэх буудал бүрд ажиллах хороог;



1.6.21.“нисэхийн аюулгүйн хамгаалалтын үүрэг хүлээсэн байгууллага” гэж иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын журмыг боловсруулах, өөрчлөх талаар санал гаргах, хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий байгууллагыг;

1.6.22.“нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр” гэж нисэх буудлыг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зорилгоор хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааг нарийвчлан тодорхойлж, энэ журмын шаардлагад нийцүүлэн боловсруулсан баримт бичгийг;

1.6.23.“нислэгийн үед хэрэглэх эд зүйлс” гэж нислэгийн үед зорчигчийн үйлчилгээнд хэрэглэх, эсхүл худалдах эд зүйлсийг;

1.6.24.“нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага” гэж Иргэний нисэхийн дүрмийн дагуу гэрчилгээжсэн, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үүргийг гүйцэтгэх хуулийн этгээдийг;

1.6.25.“нийтийн хэв журам зөрчсөн зорчигч” гэж нисэх буудал, агаарын хөлөгт баримтлах дүрэм, журам болон нисэх буудлын ажилтан, нисэх багийн гишүүний шаардлагыг биелүүлээгүй, нисэх буудал болон агаарын хөлгийн хэвийн ажиллагааг алдагдуулсан этгээдийг;

1.6.26.“онцгой анхаарлын цэг” гэж гэмтлийн улмаас иргэний нисэхийн үйл ажиллагаанд ноцтой саад учруулж болзошгүй нисэх буудлын барилга байгууламж, тоног төхөөрөмжийг;

1.6.27.“тусгай зориулалтын нислэг” гэж хөдөө аж ахуй, барилга байгууламжийн зураг авалт, хайгуул, ажиглалт, болон эргүүл хийх, эрэн хайх, авран туслах, зар сурталчилгаа явуулах зэрэг үйлчилгээ үзүүлэх зорилгоор гүйцэтгэж байгаа нислэгийг;

1.6.28.“тээш ялгах талбай” гэж тээшийг аяллын дугаар, чиглэлээр нь ялгах талбайг;

1.6.29.“танигдаагүй тээш” гэж нисэх буудалд тээшний зүүлттэй, эсхүл зүүлтгүйгээр ирсэн болон эзэн нь тогтоогдоогүй, эсхүл хүлээн аваагүй тээшийг;

1.6.30.“тогтмол илгээгч” гэж аюулгүйн хамгаалалтын нийтлэг дүрэм, шаардлагыг хангасан ачаа, шууданг тээвэрлэгчийн хяналтад шилжүүлж, агаарын хөлгөөр тээвэрлэхийг зөвшөөрсөн этгээдийг;

1.6.31.“үйлчилгээнд гарсан агаарын хөлөг” гэж нислэгт бэлэн болж баталгаажсан, аяллын дугаар олгогдсон, зорчигчийг хүлээн

авах бэлтгэлийг хангаж, агаарын хөлгийн диспетчерийн хяналтад орсон, зогсоолд байрласан агаарын хөлгийг;

1.6.32.“үзлэгийн дараах бүс” гэж аюулгүйн үзлэгийн цэг болон агаарын хөлгийн хоорондох хэсгийг;

1.6.33.“үнэмлэх олгох” гэж хамгаалалттай бүсэд нэвтрэх этгээдийг үүргээ зохих түвшинд гүйцэтгэх чадвартайг эрх бүхий байгууллагаас үнэлж, баталгаажуулах үйл ажиллагааг;

1.6.34.“сэжигтэй эд зүйлс” гэж эзэнгүй, эсхүл эзнийг нь тогтоох боломжгүй, аюултай байж болзошгүй эд зүйлсийг;

1.6.35.“өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс” гэж аюулгүйн хамгаалалттай бүс дэх илүү эрсдэлтэй гэж тодорхойлсон, нэвтрүүлэх хяналт, бусад аюулгүйн хамгаалалтын хяналт илүү шаардлагатай хэсгийг;

1.6.36.“өндөр эрсдэлтэй ачаа, шуудан” гэж иргэний нисэхийн үйл ажиллагаанд аюул учруулж болзошгүй, сэжигтэй, хэвийн бус, эсхүл хөндөгдсөн байж болзошгүй ачаа, шууданг;

1.6.37.“хориглосон эд зүйлс” гэж агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон, эсхүл зөвхөн тусгай журмын дагуу тээвэрлэх, хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй эд зүйлсийг;

1.6.38.“хөндлөнгийн хууль бус үйлдэл” гэж иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтад нөлөөлөх дараах үйлдэл болон завдалтыг:

1.6.38.1.агаарын хөлгийг хууль бусаар булаан эзлэх;

1.6.38.2.агаарын хөлгийг устгах;

1.6.38.3.агаарын хөлөгт болон нисэх буудалд хүн барьцаалах;

1.6.38.4.агаарын хөлөг, нисэх буудлын аюулгүйн хамгаалалттай бүс болон агаарын навигацийн тоног төхөөрөмж, байгууламжид хүч түрэмгийлэн нэвтрэх;

1.6.38.5.агаарын хөлгийн бүхээг, нисэх буудалд зэвсэг, аюултай хэрэгсэл болон эд зүйлсийг нэвтрүүлэх;



1.6.38.6.үйлчилгээнд гарсан агаарын хөлгийг хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой гэмтэл учруулах, үхэлд хүргэх, эсхүл эд хөрөнгө болон хүрээлэн байгаа орчинд ноцтой хохирол учруулах зорилгоор ашиглах;

1.6.38.7.агаарын хөлгийн аюулгүй байдал, нисэх буудал, түүний барилга байгууламж, зорчигч, нисэх багийн гишүүд, газрын үйлчилгээний ажилтан болон иргэдийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй хуурамч мэдээ, мэдээлэл тараах.

1.6.39.“шилжүүлэн ачих ачаа, шуудан” гэж тээвэрлэж ирсэн агаарын хөлгөөс өөр агаарын хөлөгт шилжүүлэн ачих ачаа, шууданг;

1.6.40.“шилжин суух зорчигч” гэж нэг агаарын хөлгөөс нөгөө агаарын хөлөгт шилжин суух зорчигчийг;

1.6.41.“шуудан” гэж Дэлхийн шуудан холбооны дүрмийн дагуу шуудангийн байгууллагад хүргэх захидал болон бусад зүйлсийг;

1.6.42.“зан байдлыг таньж тогтоох” гэж иргэний нисэхэд аюул учруулж болзошгүй этгээдийг биеийн хэл, дохио зангаа зэрэг зан байдлын шинжээр нь илрүүлэхийг;

1.6.43.“зохицуулалттай ачаа зуучлалын байгууллага” гэж иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хүлээн зөвшөөрсөн, агаарын тээвэрлэгчтэй хамтран үйл ажиллагаа явуулдаг, аюулгүйн хамгаалалтын хяналтыг хангаж ажилладаг хуулийн этгээдийг;

1.6.44.“урьдчилан тааварлах боломжгүй байдал” гэж аюулгүйн хамгаалалтын арга хэмжээний үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор аюулгүйн хамгаалалтын хяналт шалгалтыг өөр өөр байршилд, эсхүл өөр арга хэрэгсэл ашиглан хэрэгжүүлэхийг;

1.6.45.“Зөвлөл” гэж энэ журмын 3.1-д тодорхойлсныг.

1.7.Олон улсын гэрээ, конвенц:

-“Олон улсын иргэний нисэхийн тухай” 1944 оны Чикагогийн конвенц;

-“Агаарын хөлгийн бүхээгт үйлдсэн гэмт хэрэг болон тодорхой бусад үйлдлийн тухай” 1963 оны Токиогийн конвенц болон түүний нэмэлт протокол;

-“Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай” 1970 оны Гаагийн конвенц болон түүний нэмэлт протокол;

-“Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын эсрэг хууль бус үйлдлийг хориглох тухай” 1971 оны Монреалын конвенц болон түүний нэмэлт протокол;

-“Хуванцар тэсрэх бодис илрүүлэх зорилгоор тэмдэг тавих тухай” 1991 оны Монреалын конвенц;

-“Олон улсын иргэний нисэхэд үйлчилдэг нисэх буудал дахь хүч хэрэглэсэн хууль бус үйлдлийг хориглох тухай” 1988 оны Монреалын конвенц болон түүний нэмэлт протокол;

-Олон улсын иргэний нисэхийн эсрэг хууль бус үйлдэлтэй тэмцэх тухай конвенц.

1.8.Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангахтай холбоотой Монгол Улсын хууль, дүрэм:

-Монгол Улсын Үндсэн хууль;

-Иргэний нисэхийн тухай хууль;

-Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль;

-Төрийн тусгай хамгаалалтын тухай хууль;

-Монгол Улсын хилийн тухай хууль;

-Эрүүгийн хууль;

-Кибер аюулгүй байдлын тухай хууль;

-Төрийн болон албаны нууцын тухай хууль,

-Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль;

-Галт зэвсгийн тухай хууль;

-Гэрээт харуул хамгаалалтын тухай хууль;

-Зөрчлийн тухай хууль;



-Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль;

-Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль;

-Иргэний нисэхийн багц дүрэм, тэдгээрийн зөвлөмжийн цувралууд.

1.9.Бусад улстай байгуулах агаарын харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах зохицуулалтыг заавал тусгана.

1.10.Нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах арга хэмжээг бусад улсын эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээтэй давхардуулахаас сэргийлж, аюулгүйн хамгаалалтын тогтвортой тогтолцоог бүрдүүлэхийн тулд бусад улсын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай хамтын ажиллагааны гэрээ байгуулах боломжийг эрэлхийлэх бөгөөд аялал эхлэх улсад хэрэгжүүлж байгаа аюулгүйн хамгаалалтын хяналтын арга хэмжээ нь ижил түвшинд байгааг баталгаажуулсны үндсэн дээр холбогдох гэрээг байгуулна.

1.11.Хөндлөнгийн хууль бус үйлдлийн эсрэг хариу арга хэмжээний зохицуулалтын талаар хэлэлцэн тохиролцогч бусад улстай мэдээлэл солилцож, Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэнэ.

Хоёр.Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын талаар иргэний нисэхийн болон бусад байгууллагын бүрэн эрх, үүрэг

2.1.Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “Ерөнхий газар” гэх) нь Монгол Улсын иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг хариуцан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

2.1.1.иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын журмыг боловсруулах, хэрэгжилтийг хангах үүрэг бүхий болон бусад оролцогч байгууллагын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлох;

2.1.2.энэ журамд нэмэлт, өөрчлөлт орох бүрд нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний болон бусад байгууллагад мэдэгдэх;

2.1.3.бусад улсын эрх бүхий байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу тухайн улсын агаарын тээвэрлэгчийн тусгай зориулалтын нислэгт аюулгүйн хамгаалалтын нэмэлт арга хэмжээ авах;

2.1.4.шаардлагатай бол нисэхийн аюулгүйн хамгаалалтын сургалтын болон чанарын хяналтын хөтөлбөрийг бусад улсын эрх бүхий байгууллагатай хамтран боловсруулж, мэдээлэл, санал солилцох;

2.1.5.иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангахтай холбоотой баримт, мэдээллийг хамгаалах журмыг баталж, хэрэгжүүлэх;

2.1.6.нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага, ачаа, шуудан тээвэр, нислэгийн хоол хүнс бэлтгэх байгууллагын аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр, түүнд оруулсан өөрчлөлтийг тогтмол хянаж баталгаажуулах;

2.1.7.хөндлөнгийн хууль бус үйлдлийн үед хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ, үйл ажиллагаанд үнэлэлт өгч, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэх;

2.1.8.агаарын хөлөгт хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болзошгүй зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, сэжигтэй эд зүйлийг нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний журмыг батлах;

2.1.9.нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний болон холбогдох бусад байгууллага өөрсдийн аюулгүйн хамгаалалтыг хангах үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээг үр дүнтэй хийх зорилгоор мэдээлэл солилцох журмыг баталж, хэрэгжүүлэх;

2.1.10.олон улсын нисэх буудлын үйл ажиллагаанд жилд нэг удаа эмзэг байдлын үнэлгээ хийж, аюулгүйн хамгаалалтыг сайжруулахад мэдээлэл болгон ашиглах;

2.1.11.“Олон улсын иргэний нисэхийн тухай” 1944 оны Чикагогийн конвенцын Хавсралт 17-д тусгасан холбогдох стандарт, зөвлөмжийг олон улсын гэрээ, хууль тогтоомжид нийцүүлэн батлуулах;

2.1.12.энэ журмын шаардлагад нийцүүлэн иргэний нисэхийн дүрэм, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, холбогдох заавар, журмыг боловсруулж, батлуулах;



2.1.13.энэ журмын хэрэгжилтийг хангах үүрэг бүхий болон бусад оролцогч байгууллагын ажилтныг бэлтгэх сургалтын бодлогын баримт бичгийг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.14.бусад улсын эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргасан тохиолдолд Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас хийсэн аюулгүйн хамгаалалтын аудитын тайлан болон илэрсэн дутагдлыг арилгах чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг бэлтгэн хүргүүлэх;

2.1.15.Зөвлөл болон нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хорооны холбогдох байгууллага, агентлаг, бусад төрийн байгууллага, хуулийн этгээдийн хэрэгжүүлж байгаа нийтийн эзэмшлийн бүсийн аюулгүйн хамгаалалтыг хангах арга хэмжээний зохицуулалтыг баталж, нийтийн эзэмшлийн бүсийн аюулгүйн хамгаалалтын талаар тухайн байгууллагын хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлох;

2.1.16.нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нислэгийн хөдөлгөөний болон иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, тухайн нисэх буудалд үйл ажиллагаа явуулж байгаа бусад байгууллагад нисэхийн аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн үнэлгээ, аудит, үзлэг шалгалт, сорилт хийх, дүгнэлт гаргах;

2.1.17.энэ журмын хэрэгжилтийн үр дүнг баталгаажуулах, нийцлийг тодорхойлох зорилгоор иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын чанарын хяналтын хөтөлбөрийг баталж мөрдүүлэх, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

2.1.18.нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай болон аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх журмыг баталж мөрдүүлэх;

2.1.19.олон улсын нисэх буудал дахь улсын хилийн бүсэд нэвтрэх журмыг хил хамгаалах байгууллагатай хамтран батлах;

2.1.20.гадаад улсаас Монгол Улсад нислэг үйлдэж байгаа агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр, түүнд оруулсан өөрчлөлтийг хянаж, хүлээн зөвшөөрөх;

2.1.21.иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын стандарт, дүрэм, журмыг боловсруулах, мөрдүүлэх, нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх хүн, зорчигч, тэдгээрийн гар тээш, тээш болон ачаа, илгээмж, шуудан, эд зүйлсэд аюулгүйн үзлэг, шалгалт хийх байгууллагыг гэрчилгээжүүлэх;

2.1.22.нийтийн эзэмшлийн бүсийг баталгаажуулах.

2.2.Нисэх буудал нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

2.2.1.хууль тогтоомж, энэ журамд нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журам, заавар болон тухайн нисэх буудлын үйл ажиллагааны онцлогт нийцсэн нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх;

2.2.2.аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах үүрэг бүхий аюулгүйн хамгаалалтын ажилтныг томилох;

2.2.3.нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хороог байгуулах;

2.2.4.энэ журам болон нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, зохицуулалтын арга хэмжээ авах, нисэх буудлын удирдлагыг шаардлагатай зөвлөгөө, мэдээллээр хангах зорилгоор нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хороог тогтмол хугацаанд хуралдуулах;

2.2.5.нисэхийн аюулгүйн хамгаалалтын үзлэг, шалгалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;

2.2.6.шинээр тоног төхөөрөмж суурилуулах, нисэх буудлын барилга байгууламж барих, өргөтгөх ажлыг аюулгүйн хамгаалалтын шаардлагад нийцүүлэн Ерөнхий газрын зөвшөөрлөөр гүйцэтгэх;

2.2.7.хөндлөнгийн хууль бус үйлдэл гарсан онцгой байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээний зааварчилгааг тусгасан журам баталж хэрэгжүүлэх;

2.2.8.онцгой байдал үүссэн үед нисэх буудлын үйл ажиллагаа, аюулгүйн хамгаалалтын арга хэмжээг удирдан зохицуулах онцгой байдлын үйл ажиллагааны төвийг байгуулж ажиллуулах;

2.2.9.энэ журам болон нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт заасан нисэхийн аюулгүйн хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилтэд эрсдэлийн үнэлгээг жил бүр нэгээс доошгүй удаа хийх.

2.3.Дотоодын болон гадаадын агаарын тээвэрлэгч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:



2.3.1.агаарын хөлөг, зорчигч, тээш, ачаа, шууданг хадгалах талбайн аюулгүйн хамгаалалтыг хангах, эсхүл аюулгүйн хамгаалалтыг хангах үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

2.3.2.хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах зааварчилгааг тусгасан, шаардлагад нийцсэн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр баталж хэрэгжүүлэх, энэ журмын шаардлагад оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн нэмэлт, өөрчлөлт оруулж, баталгаажуулах;

2.3.3.онцгой байдлын үед ажиллах журам баталж, хэрэгжүүлэх;

2.3.4.аюулгүйн хамгаалалт хариуцсан ажилтныг томилох;

2.3.5.аюулгүйн хамгаалалтын сургалтын хөтөлбөрийг баталж, ажилтнуудыг сургаж, дадлагажуулах;

2.3.6.гадаадын агаарын тээвэрлэгчийн төлөөлөгчийн газрын аюулгүйн хамгаалалтын журмыг энэ журмын шаардлагад нийцүүлэн батлуулах;

2.3.7.энэ журам болон агаарын тээвэрлэгчийн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт заасан нисэхийн аюулгүйн хамгаалалтын арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээг жил бүр нэгээс доошгүй удаа хийх.

2.4.Нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.4.1.энэ журмын шаардлагад нийцсэн аюулгүйн хамгаалалтын хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх;

2.4.2.аюулгүйн хамгаалалтын ажилтныг томилох;

2.4.3.нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хороонд өөрийн төлөөлөгчийг томилж ажиллуулах;

2.4.4.нисэхийн аюулгүйн үзлэг, шалгалт хийх зориулалттай тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах;

2.4.5.нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний системийг цахим халдлагаас хамгаалах журам баталж, хэрэгжүүлэх;

2.4.6.энэ журам болон нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллагын аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт заасан нисэхийн аюулгүйн хамгаалалтын арга хэмжээ, тэдгээрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлэх эрсдэлийн үнэлгээг жил бүр нэгээс доошгүй удаа хийх.

2.5.Тагнуулын байгууллага дараах үүрэгтэй:

2.5.1.иргэний нисэхийн эсрэг заналхийллийн үед авах арга хэмжээний нэгдсэн журмыг боловсруулж, хэрэгжүүлэх;

2.5.2.иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтад нөлөөлөх мэдээлэл цуглуулах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;

2.5.3.энэ журам болон бусад баримт бичигт заасан байгууллагын ашигладаг иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын чухал мэдээлэл, харилцаа, холбооны систем, өгөгдлүүдийг тодорхойлж, эрх бүхий байгууллагын хийсэн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн хууль бус халдлагаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.5.4.нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрүүлэх худалдааны болон хангамжийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн дамжлага бүрийн аюулгүйн хамгаалалт, харилцаа холбооны систем, өгөгдлүүдийн аюулгүйн хамгаалалтын төлөвлөлт, сүлжээний тусгаарлалт, хамгаалалт, алсын тандалтын хязгаарлалтын арга хэмжээ авсныг баталгаажуулах;

2.5.5.терроризмтой тэмцэх, барьцаалагчтай хэлэлцээ хийх, тэсрэх төхөөрөмж устгах зэрэг хөндлөнгийн хууль бус үйл ажиллагаатай тэмцэх тусгай мэргэжлийн багийг томилох;

2.5.6.аюулгүйн хамгаалалтын үзлэгээр зорчигчоос зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, сэжигтэй эд зүйлс илэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу аюулгүй болгох арга хэмжээ авах;

2.5.7.эрсдэлийн үнэлгээ хийхэд ашиглах иргэний нисэхийн эсрэг заналхийллийн мэдээллийг нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага болон холбогдох бусад байгууллагатай солилцох.

2.6.Цагдаагийн байгууллага иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтыг иргэний нисэхийн байгууллагатай хамтран зохион байгуулах бөгөөд дараах үүрэгтэй:



2.6.1.иргэний нисэхийн барилга байгууламжид гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журмыг сахиулах;

2.6.2.иргэний нисэхэд аюул учруулж болзошгүй этгээд, зорчигчид тандалт хийх;

2.6.3.хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх болон агаарын хөлгийг хууль бусаар булаан авах, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, тэсрэх бодис хэрэглэхээр сүрдүүлэх, нисэх буудал болон бусад барилга байгууламжид халдах, нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед авах арга хэмжээ, үйл ажиллагааг нисэх буудлын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх;

2.6.4.цагдаагийн алба хаагчдыг нисэхийн аюулгүйн хамгаалалтын сургалтын хөтөлбөрийн дагуу сургаж, дадлаажуулах;

2.6.5.шаардлагатай тохиолдолд зорчигчийг саатуулах зорилгоор үзлэгийн цэгт цагдаагийн ажилтныг байнга ажиллуулах;

2.6.6.хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор эрх бүхий байгууллагын хийсэн нисэхийн аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн үнэлгээнд үндэслэн нийтийн эзэмшлийн бүсийн аюулгүйн хамгаалалтыг хангах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх;

2.6.7.нисэх буудлын нийтийн эзэмшлийн бүсэд хяналт тавьж, эргүүл ажиллуулах.

2.7.Хил хамгаалах байгууллага хилийн боомт бүхий олон улсын нисэх буудалд аюулгүйн хамгаалалтыг хангах ажлыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн болон холбогдох бусад байгууллагатай хамтран зохион байгуулах бөгөөд дараах үүрэгтэй:

2.7.1.иргэний нисэхийн үйл ажиллагаанд заналхийлэл учруулж болзошгүй этгээдийг илрүүлэх зорилгоор зорчигчийн мэдээллийг шалгах, шаардлагатай үед холбогдох мэдээллийг иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын байгууллагад хүргүүлэх;

2.7.2.Ерөнхий газрыг шаардлагатай мэдээллээр хангах;

2.7.3.хилийн боомтод онцгой нөхцөл үүссэн үеийн ажиллагааны төлөвлөгөөг онцгой байдлын үед ажиллах журамтай уялдуулан баталж, хэрэгжүүлэх.

2.8. Нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээний байгууллага нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

2.8.1. өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрүүлэх худалдааны болон хангамжийн бараа, бүтээгдэхүүнд аюулгүйн үзлэг, шалгалт хийх;

2.8.2. өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай болон аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх үнэмлэх олгож, хяналт тавих;

2.8.3. өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх хүн, зорчигч, тэдгээрийн гар тээш, тээш болон ачаа, шуудан, илгээмж, агаарын тээвэрлэгчийн шуудан болон эд зүйлсэд аюулгүйн үзлэг, шалгалт хийх;

2.8.4. иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын сургалтын хөтөлбөр, стандартын дагуу ажилтнуудыг сургаж, дадлагажуулах;

2.8.5. аюулгүйн үзлэг, шалгалтыг зөвхөн эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлэх;

2.8.6. нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхдээ эрх бүхий байгууллагаас хийсэн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн шалгах.

2.9. Хил хамгаалах болон хилийн хяналтын байгууллага, нисэх буудалд гэрээний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд, байгууллага нь ажилтнаа нисэхийн аюулгүйн хамгаалалтын холбогдох сургалтад хамруулах, нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай, аюулгүйн хамгаалалттай болон үзлэгийн дараах бүсэд нэвтрэх журмыг мөрдөх үүрэгтэй.

2.10. Хил хамгаалах болон хилийн хяналтын байгууллага, нисэх буудалд үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд, байгууллага нь иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын ажиллагааг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангахтай холбогдуулан Ерөнхий газар, тагнуулын болон цагдаагийн байгууллагын хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.

2.11. Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын журамд заасан оролцогч болон аюулгүйн хамгаалалтыг хангах үүрэг бүхий байгууллагын бүх ажилтан, нисэх буудлын аюулгүйн хамгаалалттай бүсэд дагалдах



хүнгүйгээр нэвтрэх эрх бүхий этгээдийг аюулгүйн хамгаалалтын талаар мэдлэг олгох анхан болон давтан сургалтад хамруулна.

2.12.Нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах үүрэг бүхий байгууллага нь чиг үүргээ гэрээний үндсэн дээр мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байгаа бол аюулгүйн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, баталгаажуулна.

2.13.Нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах үүрэг бүхий байгууллага нь өөрийн газар нутаг, агаарын зайд учирч болох иргэний нисэхийн заналхийллийн шинж болон түвшнийг тогтмол хянаж, холбогдох эрх бүхий байгууллагын хийсэн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн энэ журамд нийцсэн бодлого, журам баталж, хэрэгжүүлнэ.

2.14.Нислэгийн хоол хүнс бэлтгэх байгууллага нь хоол хүнс болон агаарын хөлгийн хангалтад хэрэглэх эд зүйлд зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, бусад аюултай зүйлийг нууж нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр баталж, хэрэгжүүлнэ.

2.15.Нисэх буудалд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага болон хувийн хэвшлийн хуулийн этгээд энэ журамд заасан шаардлагыг биелүүлж, дараах үүргийг хүлээнэ:

2.15.1.ажилтнуудыг хялбар таньж, тодорхойлох боломжтой, зөв зохистой хувцаслах;

2.15.2.нисэх буудалд эрхэлж байгаа үйл ажиллагаа нь нислэгийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтад харшлахгүй байх;

2.15.3.ажилтнуудыг аюулгүйн хамгаалалтын сургалтад хамруулах;

2.15.4.нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс болон агаарын хөлөгт зөвшөөрөгдөөгүй эд зүйлс нэвтрүүлэхгүй байх.

2.16.Иргэний нисэхийн байгууллагууд нь иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтад сөргөөр нөлөөлж болзошгүй аливаа гэмт үйлдэл, үйл ажиллагаа, аюул, заналхийллийн талаарх мэдээ, мэдээллийг тагнуулын байгууллага, хилийн хяналтын болон хууль сахиулах бусад байгууллагад шуурхай мэдээлэх үүрэгтэй.

2.17.Энэ журамд заасан нисэхийн аюулгүйн хамгаалалтын үүрэг хүлээсэн байгууллага нь аюулгүйн хамгаалалтын соёлыг сурталчлах, хөгжүүлэх талаар шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Гурав.Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын зөвлөл, түүний эрх, үүрэг

3.1.Иргэний нисэх, хууль зүй, дотоод хэрэг, батлан хамгаалах, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, иргэний нисэх, онцгой байдал, тагнуул, гааль, цагдаа, хил хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллага, нисэх буудал, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний болон тогтмол нислэг гүйцэтгэдэг арилжааны агаарын тээврийн байгууллагын төлөөлөл бүхий Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын зөвлөл (цаашид "Зөвлөл" гэх) ажиллана.

3.2.Зөвлөл нь энэ журмыг хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулна.

3.3.Зөвлөлийн дарга нь иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна.

3.4.Зөвлөл нь дараах бүрэн эрхтэй:

3.4.1.иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;

3.4.2.иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангуулах асуудлаар Ерөнхий газарт зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх;

3.4.3.иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдлийн үед шийдвэр гаргах;

3.4.4.аюулгүйн хамгаалалтын үзлэг, шалгалтын дүрэм, журмыг сайжруулах, техник, технологийн шинэчлэлт хийх талаар дэмжлэг үзүүлэх;

3.4.5.хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах үйл ажиллагааг боловсронгуй болгох санал боловсруулж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх;

3.4.6.хөндлөнгийн хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг таслан зогсоох, түүний хор уршгийг арилгахад иргэний нисэхийн байгууллага, аж ахуйн нэгжийн хүч, хэрэгслийг татан оролцуулах, үйл ажиллагааны уялдааг хангах;

3.4.7.нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хороонд зөвлөмж өгөх;



3.4.8.иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын тайланг хэлэлцэж, холбогдох байгууллагад хүргүүлэх;

3.4.9.нислэгийн үеийн аюулгүйн хамгаалалтын ажилтан ажиллуулах талаар гадаад, дотоодын агаарын тээвэрлэгчээс ирүүлсэн хүсэлтийг тухайн ажилтныг хүлээн авахыг зөвшөөрсөн улстай зөвхөн гэрээ байгуулсан тохиолдолд шийдвэрлэх;

3.4.10.нийтийн эзэмшлийн бүсийн аюулгүйн хамгаалалтыг хангах эрх бүхий байгууллагуудын үүргийг тодорхойлох, үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

3.4.11.эрх бүхий байгууллагаас гаргасан эрсдэлийн үнэлгээнд үндэслэн нисэх буудал болон түүний орчимд зөөврийн харвагч систем болон бусад ижил түвшний заналхийлэл учруулахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааны журам, арга хэмжээний төлөвлөгөөг батлах;

3.4.12.дотоодын агаарын тээвэрлэгчийн тусгай зориулалтын нислэгт аюулгүйн хамгаалалтын нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлэх талаар бусад улсын эрх бүхий байгууллагад хүсэлт гаргахдаа тухайн улсын нөөц арга хэмжээ нь гаргасан хүсэлттэй нь ижил түвшинд байгаа эсэх талаар хэлэлцэж, шийдвэр гаргах;

3.4.13.хууль тогтоомжийн хүрээнд шаардлагатай бусад асуудал.

3.5.Зөвлөл нь жилд хоёроос доошгүй удаа хуралдах бөгөөд хуралдааны шийдвэр, тэмдэглэлийг тухай бүр гишүүдэд хүргүүлнэ. Зөвлөлийн хуралд техникийн шинжээч, мэргэжилтнүүдийг оролцуулж болно.

3.6.Ерөнхий газар нь аль нэг улсын иргэний нисэхийн үйл ажиллагаанд аюул заналхийлж байгаа талаар мэдээллийг Зөвлөл болон тухайн улсын эрх бүхий байгууллагад тухай бүр яаралтай мэдэгдэнэ.

3.7.Зөвлөл нь энэ журмын 3.1-д заасан байгууллагын талаар Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэнэ.

Дөрөв.Нисэх буудлын аюулгүйн хамгаалалт

4.1.Нисэх буудал нь нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

4.2. Нисэх буудал нь нисэх буудлын аюулгүйн хамгаалалттай болон нийтийн эзэмшлийн бүсийг цагдаагийн байгууллагатай хамтран тогтооно.

4.3. Нисэх буудал нь эрх бүхий байгууллагын хийсэн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн хөндлөнгийн хууль бус үйлдэл, учирч болзошгүй аюулыг бууруулах зорилгоор нийтийн эзэмшлийн бүсийн аюулгүйн хамгаалалтыг хангах арга хэмжээг зохион байгуулна.

4.4. Хилийн боомт бүхий Олон улсын нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийг эрх бүхий байгууллагын хийсэн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн хил хамгаалах байгууллагатай зөвшилцсөнөөр Ерөнхий газар тогтооно.

4.5. Өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай, аюулгүйн хамгаалалттай болон нийтийн эзэмшлийн бүсийн хил хязгаарыг тогтоож, баталгаажуулсан бүдүүвч зургийг нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт хавсаргана.

4.6. Нисэх буудлын аюулгүйн бүсэд байрлах агаарын навигацийн байгууламж нь аюулгүйн хамгаалалттай бүстэй байна.

4.7. Нисэх буудлын аюулгүйн хамгаалалттай бүс нь хашаа, хаалт, дохиолол, гэрэлтүүлэг, камерын хяналтын системтэй, харуул хамгаалалтын ажилтантай байна.

4.8. Нисэх буудал нь өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд хүн, тэдгээрийн авч яваа эд зүйлс болон тээврийн хэрэгслийг зөвшөөрөлтэйгөөр нэвтрүүлж, хяналт тавина.

4.9. Нисэх буудал нь зорчигчоос бусад хүн, тэдгээрийн авч яваа эд зүйлсийг өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрүүлэхээс өмнө аюулгүйн үзлэг, шалгалт хийнэ.

4.10. Нисэх буудал нь зорчигч болон бусад хүн тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл авч яваа эсэхийг илрүүлэх үзлэгийг тохиромжтой аргаар хийх бөгөөд эдгээр аргыг тогтмол ашиглаагүй тохиолдолд түүвэрлэн сонгох болон урьдчилан тааварлах боломжгүй аргын аль тохирохыг ашиглана.

4.11. Хаалга, цонх, цахилгаан шат, хонгил болон бусад гарцыг ашиглаагүй тохиолдолд хаалтаар хамгаална.

4.12. Нисэх буудал нь эрх бүхий байгууллагын хийсэн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд



нэвтрэх хүн, тээврийн хэрэгсэл, түүн доторх эд зүйлсэд аюулгүйн үзлэг, шалгалт хийнэ.

4.13.Перрон, агаарын хөлгийн зогсоолын талбай болон онцгой анхаарлын цэг нь гэрэлтүүлэгтэй байна.

4.14.Нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай болон аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх үнэмлэх авах хүсэлт гаргасан этгээд эрх бүхий байгууллагын анкет шалгалтад тэнцсэн тохиолдолд үнэмлэх олгох, эсхүл зөвшөөрлийн үнэмлэх олгож болно.

4.15.Нэвтрэх үнэмлэхийн загварыг 2 жил тутам шинэчлэх бөгөөд дараах мэдээллийг тусгана:

4.15.1.үнэмлэх эзэмшигчийн зураг, эцэг/эхийн болон өөрийн нэр, эрхэлж байгаа ажил, албан тушаал;

4.15.2.үнэмлэхийн хүчинтэй хугацаа;

4.15.3.үнэмлэхийн хүчин төгөлдөр үйлчлэх бүс;

4.15.4.үнэмлэхийг ашиглахтай холбоотой зааварчилгаа.

4.16.Зорчигчийн иргэний үнэмлэх, эсхүл гадаад паспорт, хүүхдийн төрсний гэрчилгээ, тухайн хүний бичиг баримтыг орлохуйц эрх бүхий байгууллагаас гаргасан албан ёсны хүчин төгөлдөр баримт бичиг, суугчийн талон, ажилтнуудын нэвтрэх үнэмлэх, биеийн байцаалтыг тогтоосон үзлэгийн цэгт тус тус шалгасны үндсэн дээр нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрүүлнэ.

4.17.Тээврийн хэрэгслийн нэвтрэх үнэмлэхийг тухайн тээврийн хэрэгсэл нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай болон аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх хэрэгцээ, шаардлагыг харгалзан олгоно.

4.18.Тээврийн хэрэгслийн нэвтрэх үнэмлэхэд дараах мэдээллийг тусгаж салхины шилний дотор талд ил харагдахаар, хөдөлгөөнгүй байрлуулах бөгөөд үнэмлэхийн загварыг 2 жил тутам шинэчилнэ:

4.18.1.тээврийн хэрэгслийн марк, улсын дугаар;

4.18.2.тээврийн хэрэгслийн өмчлөгч болон жолоочийн нэр;

4.18.3.үнэмлэхийн хүчинтэй хугацаа;

4.18.4.үнэмлэх хүчин төгөлдөр үйлчлэх бүс;

4.18.5.үнэмлэхийг ашиглахтай холбоотой зааварчилгаа.

4.19.Нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай болон аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх тээврийн хэрэгслийн тоонд хязгаарлалт тогтоож болно.

4.20.Нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай болон аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх тээврийн хэрэгсэлд зөвшөөрөлгүй хүн, эд зүйлс нэвтрүүлэх, тээвэрлэхийг хориглоно.

4.21.Нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай болон аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх хүн, тэдгээрийн эд зүйлс, тээврийн хэрэгсэлд хийх аюулгүйн үзлэг, шалгалтын журмыг нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгана.

4.22.Нисэх буудал нь өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд байгаа агаарын хөлөгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор хүн болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавина.

4.23.Нисэх буудал нь өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрүүлэх худалдааны болон хангамжийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн шат, дамжлага бүрд аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагаа, аюулгүйн үзлэг, шалгалт хийнэ.

4.24.Хилийн боомт бүхий олон улсын нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай, аюулгүйн хамгаалалттай болон хилийн хяналт шалгалтын бүсэд нэвтрэх үнэмлэхийг хил хамгаалах байгууллагатай хамтран олгож болно.

4.25.Хилийн боомт бүхий олон улсын нисэх буудалд эрсдэлтэй зорчигч, сэжигтэй эд зүйл, ачаа тээш илэрсэн тохиолдолд тухай бүр хил хамгаалах байгууллагад мэдэгдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд хил хамгаалах байгууллагын ажилтан олон улсын нисэх буудлын хяналт шалгалтын бүсэд тухайн этгээдийг саатуулах, харгалзах, хуяглан хүргэх зэрэг ажиллагааг гүйцэтгэнэ.

Тав.Агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалт

5.1.Агаарын тээвэрлэгч нь өөрийн агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалтыг хэрэгжүүлнэ.



5.2. Агаарын тээвэрлэгч нь агаарын хөлөгт аюулгүйн үзлэг, шалгалт хийж, хяналт тавих үүрэгтэй.

5.3. Агаарын тээвэрлэгч нь эрх бүхий байгууллагын хийсэн аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн үнэлгээнд үндэслэн агаарын хөлөгт аюулгүйн үзлэг, шалгалт хийнэ.

5.4. Агаарын тээвэрлэгч нь үзлэг, шалгалт хийсэн агаарын хөлөгт зөвшөөрөлгүй этгээд нэвтрэхээс сэргийлж, агаарын хөлгийг хөөрөх хүртэл хамгаална.

5.5. Агаарын тээвэрлэгч нь агаарын хөлөг нислэг үйлдэхээр өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэхээс өмнө болон шаардлагатай тохиолдолд тус бүсэд байрлуулсны дараа аюулгүйн хамгаалалтын үзлэг, шалгалт хийнэ.

5.6. Агаарын тээвэрлэгч нь үйлчилгээнд гарсан агаарын хөлөгт аюулгүйн хамгаалалтын үзлэг, шалгалт хийнэ.

5.7. Агаарын тээвэрлэгч нь агаарын хөлөгт аюулгүйн хамгаалалтын үзлэг, шалгалт хийсний дараа зөвшөөрөлгүй этгээд агаарын хөлөгт нэвтрэхээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үүрэгтэй.

5.8. Агаарын тээвэрлэгч нь үйлчилгээнд гараагүй агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалтыг хангах талаар дараах арга хэмжээ авна:

5.8.1. зорчигч болон ачаа, тээш ачих, буулгах төхөөрөмжийг холдуулах;

5.8.2. агаарын хөлгийн бүх хаалгыг хаах, түгжих, лацдах.

5.9. Агаарын хөлөгт доор дурдсанаас бусад этгээд суух, нэвтрэхийг хориглоно:

5.9.1. албан үүргээ гүйцэтгэж байгаа нэвтрэх үнэмлэхтэй агаарын тээвэрлэгчийн болон үйлчилгээний ажилтан;

5.9.2. тухайн агаарын хөлгөөр зорчих тийз, суугчийн талонтой зорчигч.

5.10. Агаарын тээвэрлэгч нь иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор тийз, нислэгийн захиалгын хуудас, суугчийн талон, тээшний зүүлт, шуудангийн лац болон ачааны баримт бичгийг өөрийн хяналт, хамгаалалтад байлгана.

5.11.Агаарын тээвэрлэгч нь дамжин өнгөрөх нислэгийн буух зорчигчийн үлдээсэн эд зүйлсийг агаарын хөлөг хөөрөхөөс өмнө буулгах, эсхүл өөрийн хяналтад байлгах болон холбогдох бусад арга хэмжээг авна.

5.12.Агаарын тээвэрлэгч нь зорчигч агаарын хөлгөөс буухдаа эд зүйлээ орхисон эсэхийг шалгаж, баталгаажуулах үүрэгтэй.

Зургаа.Зорчигч, тэдгээрийн гар тээшний аюулгүйн хамгаалалт

6.1.Нисэх буудал нь аялал эхлүүлж байгаа болон дамжин өнгөрөх, шилжин суух зорчигч, тэдгээрийн гар тээш, дамжин өнгөрөх тээшинд өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс болон үзлэгийн дараах бүсэд нэвтрэхээс өмнө аюулгүйн үзлэг, шалгалт хийнэ.

6.2.Зорчигчид хийх аюулгүйн үзлэг, шалгалтыг дараах аргаар, эсхүл хослуулан хийнэ:

6.2.1.металл илрүүлэгч хаалга;

6.2.2.гараар шалгах;

6.2.3.гар багажаар шалгах.

6.3.Зорчигч, тэдгээрийн гар тээшинд хийх аюулгүйн үзлэг, шалгалтын журмыг нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусгаж хэрэгжүүлнэ.

6.4.Төрийн тусгай хамгаалалтад байгаа албан тушаалтан, иргэнийг аюулгүйн үзлэг, шалгалтаас чөлөөлнө.

6.5.Зорчигчийн гар тээшинд хийх аюулгүйн үзлэг, шалгалтыг дараах аргаар эсхүл хослуулан хийнэ:

6.5.1.гараар шалгах;

6.5.2.рентген төхөөрөмжөөр шалгах;

6.5.3.тэсрэх бодисын ул мөр илрүүлэгчээр шалгах.

6.6.Зорчигчийн гар тээшинд рентген төхөөрөмжөөр үзлэг хийхэд сэжиг бүхий зүйл илэрсэн тохиолдолд тухайн зорчигчийг байлцуулан гараар шалгах бөгөөд эд зүйлсэд хүргэхгүй, ойртуулахгүй байна.



6.7.Рентген төхөөрөмжөөр үзлэг хийсэн нийт зорчигчийн гар тээшний 10-аас доошгүй хувьд сонгох журмаар гараар шалгалт хийнэ.

6.8.Рентген төхөөрөмж ажиллаагүй тохиолдолд гар тээшийг гараар шалгах бөгөөд тухайн гар тээш, түүнд агуулагдаж байгаа эд зүйлсийг нэг бүрчлэн шалгана.

6.9.Их хэмжээний үнэт зүйл авч яваа болон тусгай үйлчилгээ шаардлагатай, тусгай хэрэгцээт зорчигчид аюулгүйн үзлэг, шалгалтыг тусад нь хийнэ.

6.10.Нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс болон үзлэгийн дараах бүсэд нэвтрэх нисэх баг, хилийн хяналтын байгууллага, төрийн тусгай хамгаалалт болон үйлчилгээний ажилтанд аюулгүйн үзлэг, шалгалт хийнэ.

6.11.Дипломат төлөөлөгчид аюулгүйн үзлэг, шалгалт хийнэ. Дипломат төлөөлөгчийн гар тээш, дипломат ачаа тээшинд үзлэг хийхдээ Дипломат харилцааны тухай 1961 оны Венийн конвенцын холбогдох заалтын дагуу өөрийг нь, эсхүл түүнийг төлөөлөх бүрэн эрхт төлөөлөгчийг байлцуулна.

6.12.Зохих журмын дагуу лацадсан дипломат шууданд аюулгүйн үзлэг, шалгалт хийхгүй.

6.13.Ажил үүргээ гүйцэтгэж яваа хууль сахиулах байгууллага болон төрийн тусгай хамгаалалтын ажилтан нь агаарын хөлгийн бүхээгт зэвсэг, тусгай хэрэгсэлтэй нэвтрэх тохиолдолд дараах шаардлагыг хангана:

6.13.1.зэвсэг, тусгай хэрэгсэл авч явах тухай эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй байх;

6.13.2.нисэн очих болон маршрутын дагуу бууж, хөөрөх улсын эрх бүхий байгууллагад зэвсэг, тусгай хэрэгсэл авч явах зөвшөөрөлтэй талаар мэдэгдэх;

6.13.3.зэвсэг, тусгай хэрэгсэл авч яваа талаар очих улсын нисэх буудалд урьдчилан мэдэгдэх;

6.13.4.нислэгийн үед согтууруулах ундааны зүйлээр үйлчлэхгүй байх;

6.13.5.зэвсэг, тусгай хэрэгсэл авч яваа зорчигчийн тоо болон тэдгээрийн суудлыг нислэг эхлэхээс өмнө агаарын хөлгийн даргад мэдэгдсэн байх;

6.13.6.зэвсэг, тусгай хэрэгсэл биедээ авч яваа зорчигчийг агаарын хөлөгт суухаас өмнө нислэгийн маршрутын дагуу хөөрч, буух болон очих улсын холбогдох дүрэм, журмын талаарх зааварчилгааг өгсөн байх;

6.13.7.агаарын хөлгийн бүхээгт 2 болон түүнээс дээш тооны зэвсэгтэй ажилтан явах тохиолдолд агаарын тээвэрлэгч нь тэдэнд суудлын байршлыг нь мэдэгдэх.

6.14.Дараах шаардлагыг хангасан тохиолдолд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй зэвсэг, тусгай хэрэгслийг агаарын хөлгийн зорчигчийн бүхээгээс бусад хэсэгт тээвэрлэнэ:

6.14.1.зэвсэг, тусгай хэрэгсэл цэнэггүй байх;

6.14.2.зэвсэг, тусгай хэрэгслийг нислэгийн турш хүрэх боломжгүй газарт байрлуулсан байх.

6.15.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага нь хууль сахиулах байгууллагын хяналтад байгаа болон бие даан зорчих чадваргүй сэтгэцийн өвчтэй зорчигч, эсхүл Монгол Улсаас албадан гаргаж байгаа болон тухайн улсад нэвтрүүлэхийг хориглосон этгээдийг тээвэрлэх талаар агаарын тээвэрлэгчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.

6.16.Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон хил хамгаалах байгууллага нь Монгол Улсад нэвтрүүлэхийг хориглосон, эсхүл Монгол Улсаас албадан гаргаж байгаа зорчигчийг агаарын хөлгөөр тээвэрлэх талаар дамжин өнгөрөх болон очих улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэж, тэдгээрийн учруулж болзошгүй аюул заналхийллийн талаарх мэдээллийг урьдчилан хүргүүлнэ.

6.17.Агаарын тээвэрлэгч нь хууль сахиулах байгууллагын хяналтад байгаа этгээдийг тээвэрлэхэд тавигдах аюулгүйн хамгаалалтын арга хэмжээ, журмыг аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

6.18.Агаарын тээвэрлэгч нь хууль сахиулах байгууллагын хяналтад байгаа зорчигчийг харгалзагчийн хамт, бие даан зорчих чадваргүй сэтгэцийн өвчтэй зорчигчийг асран хамгаалагчийн хамт тус тус тээвэрлэнэ.

6.19.Аюулгүйн үзлэг, шалгалтаар зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл илэрсэн тохиолдолд хураан авч, тагнуулын болон цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.



6.20.Эрх бүхий байгууллагаас тээвэрлэхийг зөвшөөрсөн зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, аюултай эд зүйлийг зорчигчдоос тусгаарлан агаарын хөлгийн ачааны хэсэгт тээвэрлэнэ.

6.21.Аюулгүйн үзлэг, шалгалтаас татгалзсан болон зайлсхийсэн зорчигчийг үзлэгийн дараах бүсэд нэвтрүүлэхгүй бөгөөд агаарын хөлгөөр тээвэрлэх гэрээг цуцална.

6.22.Зохих журмын дагуу аюулгүйн үзлэг, шалгалт хийсэн зорчигч, тэдгээрийн гар тээшийг агаарын хөлөгт нэвтрүүлэх хүртэл хяналт тавина.

6.23.Аюулгүйн үзлэг, шалгалтаар ороогүй зорчигч үзлэгийн дараах бүс болон агаарын хөлөгт нэвтэрсэн тохиолдолд дараах арга хэмжээ авна:

6.23.1.үзлэгийн дараах бүсийг бүрэн чөлөөлж, дахин шалгах;

6.23.2.зорчигч, тэдгээрийн гар тээшийг үзлэгт оруулах;

6.23.3.үзлэгт хамрагдаагүй зорчигч агаарын хөлөгт нэвтэрсэн тохиолдолд агаарын хөлгийн аюулгүйн үзлэг, шалгалтыг дахин хийх.

6.24.Агаарын тээвэрлэгч нь зорчигчийг агаарын хөлөгт суухаас өмнө түүний бичиг баримт, суугчийн талоньг зорчигчийн нэрсийн жагсаалттай тулган шалгаж, тээш тээвэрлүүлэхээр бүртгүүлсэн зорчигч мөн эсэхэд давхар хяналт тавина.

6.25.Агаарын тээвэрлэгч нь нийтийн хэв журам зөрчсөн зорчигчид авах аюулгүйн хамгаалалтын арга хэмжээ, нийтийн хэв журам зөрчсөн, эсхүл хууль сахиулах байгууллагын хяналтад байгаа зорчигчийг тээвэрлэх журмыг аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

6.26.Нисэх буудал нь эрх бүхий байгууллагын хийсэн эрсдэлийн үнэлгээг үндэслэн эрсдэл тооцож, зорчигчийн гутлыг тайлуулж, рентген төхөөрөмжөөр шалгах арга хэмжээ авна.

Долоо.Тээшний аюулгүйн хамгаалалт

7.1.Аялал эхлүүлж байгаа, дамжин өнгөрөх, шилжин суух зорчигчийн гар тээш, дамжин өнгөрөх тээшинд өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүс болон үзлэгийн дараах бүсэд нэвтрэхээс өмнө аюулгүйн үзлэг, шалгалт хийнэ.

7.2.Агаарын тээвэрлэгч нь тээшний бүртгэл болон бүртгэгдсэн тээшинд тавигдах аюулгүйн хамгаалалтын арга хэмжээ, журмыг аюулгүйн хамгаалалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлнэ.

7.3.Агаарын тээвэрлэгч нь тээшний бүртгэлийг зөвхөн тухайн зорчигчийн тийз, иргэний үнэмлэх, гадаад паспорт зэрэг бичиг баримтад үндэслэн гүйцэтгэнэ.

7.4.Агаарын тээвэрлэгч нь бүлэг зорчигчийн тийзийг бүртгэхдээ зорчигч тус бүрээс тээшийг хүлээн авах журмыг баримтална.

7.5.Агаарын тээвэрлэгч нь агаарын хөлөгт суугаагүй зорчигчийн тээшийг үл дагалдах тээш гэж тодорхойлоогүй бол агаарын хөлгөөр тээвэрлэхгүй бөгөөд аюулгүйн хамгаалалтын үзлэгт хамруулна.

7.6.Тээшийг агаарын хөлөгт ачихаас өмнө рентген төхөөрөмж, тэсрэх бодисын ул мөр илрүүлэх төхөөрөмж болон био мэдрэмжийн арга хэрэгслийг ашиглан шалгана.

7.7.Сэжиг бүхий тээшийг гараар шалгана.

7.8.Аюулгүйн үзлэгийн тоног төхөөрөмж ажиллаагүй, эсхүл эвдэрсэн үед бүх тээшийг гараар шалгана.

7.9.Дараах тээшийг аюулгүйн үзлэг, шалгалтаас чөлөөлнө:

7.9.1.энэ журмын 6.4-т заасны дагуу аюулгүйн үзлэг, шалгалтаас чөлөөлөгдсөн зорчигчийн тээш;

7.9.2.өмнө нь гар тээш гэж шалгагдсан боловч агаарын хөлгийн ачааны хэсэгт тээвэрлэхээр болсон тээш.

7.10.Тээшийг агаарын хөлөгт ачихаас өмнө тээш ялгах талбай, эсхүл нисэх буудлын тээш хадгалах газарт байрлуулах бөгөөд тээш ялгах талбайд зөвхөн зөвшөөрөл бүхий этгээдийг нэвтрүүлнэ. Зөвшөөрөлгүй этгээд нэвтэрсэн тохиолдолд тээшийг агаарын хөлөгт ачихаас өмнө аюулгүйн үзлэгт дахин хамруулна.

7.11.Агаарын тээвэрлэгч нь тээшийг тухайн аяллын төгсгөлд зорчигчид хүлээлгэн өгөх, эсхүл өөр агаарын тээвэрлэгчид шилжүүлэн ачихаар хүлээлгэн өгөх хүртэл хамгаалалтад авна.

7.12.Агаарын тээвэрлэгч нь тээшийг тээвэрлэлтэд хүлээн авсан цэгээс агаарын хөлөгт ачих хүртэл аюулгүйн хамгаалалтын байнгын хяналт тавина.



7.13.Нисэх багийн тээшинд “нисэх баг” гэсэн зүүлт зүүж, бусад тээшний адил аюулгүйн үзлэг, шалгалтад хамруулна.

7.14.Агаарын тээвэрлэгч нь зөвхөн тээшний эд зүйлсийг дагалдах болон үл дагалдах гэж тодорхойлон, зохих стандартын дагуу аюулгүйн үзлэг, шалгалт хийж, тээвэрлэхээр хүлээж авах бөгөөд шалгуур хангасан бүх тээшийг бүртгэж, тээвэрлэж болохыг баталгаажуулна.

7.15.Ерөнхий газар нь бүртгэгдсэн тээшинд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл байгаа эсэхийг шалгахад ашиглах аюулгүйн үзлэг, шалгалтын аргачлалыг батална.

7.16.Нисэх буудал нь эрх бүхий байгууллагаас хийсэн аюулгүйн хамгаалалтын эрсдэлийн үнэлгээнд үндэслэн танигдаагүй тээш, сэжигтэй эд зүйлстэй харьцах журмыг тогтооно.

Найм.Ачаа болон шуудангийн аюулгүйн хамгаалалт

8.1.Агаарын хөлөгт ачаа болон шууданг ачихаас өмнө аюулгүйн үзлэг, шалгалт хийнэ.

8.2.Дипломат харилцааны тухай 1961 оны Венийн конвенцын дагуу дипломат шууданг аюулгүйн үзлэг, шалгалтаас чөлөөлнө.

8.3.Ачаа болон шуудан дахь эд зүйлийн шинж чанарыг харгалзан дараах арга, аргачлалаас тохирохыг ашиглан аюулгүйн үзлэг, шалгалтыг хийнэ:

8.3.1.гадна байдлыг харах;

8.3.2.гараар шалгах;

8.3.3.рентген төхөөрөмжөөр шалгах;

8.3.4.тэсрэх бодисын ул мөр илрүүлэгчээр шалгах;

8.3.5.био мэдрэмжийн арга хэрэгсэл болон үзлэгийн бусад арга, технологи.

8.4.Агаарын тээвэрлэгч нь тээвэрлэлтэд хүлээн авсан ачаа, шуудангийн хадгалалт, хамгаалалтыг хариуцна.

8.5.Агаарын тээвэрлэгч нь агаарын хөлгөөр тээвэрлэхээр аюулгүйн үзлэг, шалгалт хийсэн ачаа, шууданд үзлэг, шалгалтын цэгээс эхлэн агаарын хөлөг хөөрөх хүртэл байнгын хяналт тавина.

8.6. Нисэх буудал нь өндөр эрсдэлтэй ачаа, шуудангийн эрсдэлийг бууруулах зорилгоор аюулгүйн хамгаалалтын нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлнэ.

8.7. Монгол Улсаас хөөрөх агаарын хөлөгт шилжүүлэн ачих ачаа, шууданд аюулгүйн үзлэг, шалгалт хийсэн байна.

8.8. Монгол Улсын хилээр нэвтрүүлж, шилжүүлэн ачих ачаа, шууданд аюулгүйн үзлэг, шалгалт хийснийг баталгаажуулсан байна.

8.9. Зохицуулалттай ачаа зуучлалын байгууллага болон тогтмол илгээгч нь ачаанд аюулгүйн үзлэг, шалгалт хийхэд оролцох тохиолдолд иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.

8.10. Агаарын тээвэрлэгч нь агаарын хөлгөөр тээвэрлэх ачаа, шууданд зохицуулалттай ачаа зуучлалын байгууллага, тогтмол илгээгч болон Ерөнхий газраас зөвшөөрөгдсөн хуулийн этгээд аюулгүйн үзлэг, шалгалт, эсхүл аюулгүйн хамгаалалтын бусад хяналт хийснийг баталгаажуулж, зохих бүрдүүлэлт хийгээгүй бол тээвэрлэлтэд хүлээн авахгүй.

8.11. Зохицуулалттай ачаа зуучлалын байгууллага, тогтмол илгээгч, эсхүл Ерөнхий газраас зөвшөөрсөн хуулийн этгээд аюулгүйн үзлэг, шалгалт, бусад хяналтыг баталгаажуулах болон зохих бүрдүүлэлт хийх боломжгүй ачаа, шууданд аюулгүйн үзлэг, шалгалт хийлгэнэ.

8.12. Баталгаажуулсан ачаа, шууданд “Аюулгүйн хамгаалалтыг хангасан”-ыг нотолсон бичмэл хуудсыг цахим болон цаасан хэлбэрээр дагалдуулна.

8.13. Төрийн нууцын зэрэглэлтэй ачаа, шуудангийн илгээмжид зөвхөн тоног төхөөрөмжийн тусламжтайгаар аюулгүйн үзлэг хийнэ.

8.14. Мал, амьтан, тэжээвэр амьтныг ажиглаж, харааны аргаар шалгах ба хайрцаг, тор, тэдгээрийн дагалдах материалуудад аюулгүйн үзлэг, шалгалтын хамгийн тохиромжтой, үр дүнтэй аргыг ашиглана.

8.15. Аюулгүйн үзлэг, шалгалт хийснээр тухайн ачаанд агуулагдаж байгаа эд зүйлсийн онцлог шинж чанарт өөрчлөлт орж болзошгүй гэж илгээгч нь тодорхойлсон, тусгай анхаарал шаардсан эд зүйлсэд рентген төхөөрөмжөөс бусад аргыг ашиглан аюулгүйн үзлэг, шалгалт хийнэ.

8.16. Аюулгүйн үзлэг, шалгалт хийсэн ачаа, шууданг үзлэгт ороогүй ачаа, шуудантай холихгүй бөгөөд холилдсон тохиолдолд үзлэг, шалгалтыг дахин хийнэ.



**Ес.Нислэгийн үед хэрэглэх эд зүйлс, агаарын
тээвэрлэгчийн шуудан болон эд зүйлсийн
аюулгүйн хамгаалалт**

9.1.Агаарын тээвэрлэгч нь нислэгийн үед хэрэглэх эд зүйлс, агаарын тээвэрлэгчийн шуудан болон бусад эд зүйлсийг агаарын хөлөг болон нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрүүлэхдээ аюулгүйн үзлэг, шалгалт хийснийг баталгаажуулсан байна.

9.2.Нислэгийн үед хэрэглэх эд зүйлсийг бэлтгэх байгууллага нь аюулгүй байдлын хөтөлбөртөө хоол, хүнс, эд зүйлсэд зэвсэг, тэсрэх бодис болон бусад аюултай хэрэгсэл, эд зүйлс нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх талаар дараах зохицуулалтыг тусгаж, хэрэгжүүлнэ:

9.2.1.тухайн байгууллагын аюулгүйн хамгаалалтын ажилтныг томилох;

9.2.2.нисэх буудлын аюулгүйн хамгаалалтын зааврыг дагаж мөрдөх;

9.2.3.байгууллагын барилга байгууламж болон агуулахад зөвшөөрөлгүй этгээд нэвтрүүлэхгүй байх;

9.2.4.нислэгийн хоол хүнс, агаарын тээвэрлэгчийн шуудан болон эд зүйлсэд агаарын хөлгөөр тээвэрлэхийг хориглосон эд зүйлс агуулагдсан эсэхэд шалгалт хийх;

9.2.5.өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсийн гадна бэлтгэж, үзлэг хийсэн нислэгийн хоол хүнс, агаарын тээвэрлэгчийн шуудан болон эд зүйлс нь тээвэрлэлтийн үед түгжээтэй, лацтай байх;

9.2.6.агаарын тээвэрлэгчийн шуудан болон эд зүйлсийг байнгын хяналтад байлгах;

9.2.7.нислэгийн хоол хүнс бэлтгэх ажилтнуудыг аюулгүйн хамгаалалтын сургалтад хамруулах.

9.3.Агаарын тээвэрлэгч нь шуудан болон эд зүйлс нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрүүлэх, худалдааны болон хангамжийн бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн шат дамжлагад хяналт тавихдаа аюулгүйн хамгаалалтын үйл ажиллагаа, аюулгүйн үзлэгийн аргын аль тохирохыг хэрэглэнэ.

9.4.Агаарын тээвэрлэгч нь аюулгүйн хамгаалалтын хяналт шалгалт хийсэн агаарын тээвэрлэгчийн шуудан болон эд зүйлсийг тухайн агаарын хөлөгт ачих хүртэл хугацаанд хамгаална.

Арав.Аюулгүйн хамгаалалтын тоног төхөөрөмж, хэрэгсэл

10.1.Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтад дэвшилтэт технологи бүхий техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ашиглахыг зорино.

10.2.Нисэхийн аюулгүйн хамгаалалтын тоног төхөөрөмж, хэрэгслийг худалдан авах, шинэчлэхдээ Олон улсын иргэний нисэхийн байгууллагын зөвлөмжийг удирдлага болгоно.

10.3.Аюулгүйн хамгаалалтын тоног төхөөрөмж, хэрэгслийн төрөл, загвар, техникийн үзүүлэлтэд Ерөнхий газар урьдчилан зөвшөөрөл олгоно.

10.4.Нисэх буудал нь аюулгүйн хамгаалалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслийн тохируулгыг үйлдвэрлэгчээс ирүүлсэн тест, материалд үндэслэн жилд нэгээс доошгүй удаа хийж, баталгаажуулна.

10.5.Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн түвшнээс хамаарч тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдрэх чадварыг нэмэгдүүлэх эсхүл бууруулах арга хэмжээ авна.

10.6.Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангахад шаардлагатай шинэ техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологийн судалгаа хийх зорилгоор бусад улстай хамтран ажиллана.

10.7.Ерөнхий газар нь тогтоосон шалгуурт суурилсан үзлэг болон аюулгүйн хамгаалалтын хяналтын үйл ажиллагааг ялгавартай байдлаар хийх шинэ горим, журмыг баталж, хэрэгжүүлнэ.

10.8.Ерөнхий газар нь нисэх буудлуудыг иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангахад шаардлагатай нөөц, тоног төхөөрөмжтэй болохыг баталгаажуулна.

Арван нэг.Иргэний нисэхийн эсрэг заналхийлэл

11.1.Нисэх буудал болон агаарын хөлөгт аюул учруулж болзошгүй сэжигтэй үйлдлийг таних, тогтоох аргачлалыг Зөвлөлийн гишүүн байгууллагууд хамтран боловсруулна.



11.2.Иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдлээс хамгаалах арга хэмжээ нь доор дурдсан тохиолдлоос урьдчилан сэргийлэхэд чиглэнэ:

11.2.1.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл байрлуулан агаарын хөлгийг устгах, эсхүл гэмтэл учруулах;

11.2.2.агаарын хөлгийг булаан эзлэх, зорчигч, нисэх багийг барьцаалах;

11.2.3.нислэг үйлдэж буй агаарын хөлөг, зорчигч, нисэх багт аюул учруулах;

11.2.4.өндөржүүлсэн хамгаалалттай бүс болон аюулгүйн хамгаалалттай бүсэд хөндлөнгийн хууль бус үйлдэлд ашиглаж болох зүйлс, тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл, зэвсэг нэвтрүүлэх;

11.2.5.тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл байрлуулан агаарын навигацийн байгууламжийг устгах, гэмтээх болон иргэний нисэхийн үйл ажиллагаанд саад учруулах;

11.2.6.нисэх буудалд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгсэл байрлуулан олон нийтийн аюулгүй байдалд аюул учруулах.

11.3.Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн түвшнийг Нэгдүгээр түвшин (бага эсхүл “Ногоон”), Хоёрдугаар түвшин (дунд эсхүл “Шар”), Гуравдугаар түвшин (өндөр эсхүл “Улаан”) гэж ангилах бөгөөд түвшнийг дараах байдлаар тодорхойлно:

11.3.1.Нэгдүгээр түвшин-иргэний нисэхийн үйл ажиллагаа халдлагад өртөх талаар бодит мэдээ, мэдээлэл байхгүй боловч хөндлөнгийн хууль бус үйлдэл хийх боломж байгаа;

11.3.2.Хоёрдугаар түвшин-иргэний нисэхийн үйл ажиллагаа халдлагад өртөх магадлалтай гэж тодорхойлсон мэдээ, мэдээлэл байгаа;

11.3.3.Гуравдугаар түвшин-иргэний нисэхийн үйл ажиллагаа халдлагад өртөх талаар тусгайлан тодорхойлсон бодит мэдээ, мэдээлэл байгаа.

11.4.Иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдэл, учирч болзошгүй аюул, заналхийллийн түвшнийг тагнуулын байгууллага тогтоох бөгөөд нисэхийн аюулгүйн хамгаалалтын үүрэг хүлээсэн байгууллага мэргэжлийн туслалцаа үзүүлнэ.

11.5.Агаарын тээвэрлэгч, нисэх буудал, хууль сахиулах, онцгой байдлын болон холбогдох бусад байгууллага иргэний нисэхийн эсрэг заналхийллийн үед авах арга хэмжээний нэгдсэн журамд үндэслэн болзошгүй заналхийллийн үед ажиллах журмыг боловсруулж, хэрэгжүүлнэ.

11.6.Нисэх буудал, агаарын тээвэрлэгч, ачаа тээвэр зуучийн болон цагдаагийн байгууллага, холбогдох бусад байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах зорилгоор тэдгээр байгууллагын үүрэг, хариуцлагыг Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн үед авах арга хэмжээний нэгдсэн журамд тодорхой тусгана.

11.7.Энэ журмын 11.6-д заасан нэгдсэн журмыг Зөвлөл хэлэлцэж баталгаажуулна.

11.8.Тагнуулын байгууллага нь өөрийн олсон болон эрх бүхий бусад байгууллагаас ирүүлсэн мэдээ, мэдээллийг нэгтгэн боловсруулж, үнэлэн, холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдээлнэ. Тагнуулын байгууллагаас ирүүлсэн мэдээллийг нисэхийн аюулгүйн хамгаалалтын үүрэг хүлээсэн байгууллага хүлээн авмагц нисэх буудал, агаарын тээвэрлэгч болон иргэний нисэхийн бусад байгууллагад хүргүүлэн, холбогдох арга хэмжээ авна.

11.9.Нисэхийн аюулгүйн хамгаалалтын практик болон журамд иргэний нисэхэд заналхийлэл учруулж болзошгүй этгээдийн зан байдлыг илрүүлж, тодорхойлох арга зүйг нэвтрүүлнэ.

11.10.Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн Хоёрдугаар түвшний үед дараах нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлнэ:

11.10.1.дамжин өнгөрөх нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийн бүх зорчигчийг буулгаж, агаарын хөлгийн аюулгүйн хамгаалалтын үзлэгт хамруулах;

11.10.2.агаарын хөлөгт нэвтрэх үндсэн хаалга тус бүрд аюулгүйн хамгаалалтын ажилтан, эсхүл хөдөлгөөнт эргүүл гаргах;

11.10.3.агаарын хөлөгт нэвтрүүлэхээс өмнө хүзүүвчний гарц дээр явах зорчигч, тэдгээрийн гар тээш, эд зүйлсийн 10-аас дээш хувьд аюулгүйн үзлэг, шалгалт дахин хийх;

11.10.4.нислэгийн хоол хүнс, хангамжийн эд зүйлсийг агаарын хөлөгт ачихаас өмнө аюулгүйн үзлэг, шалгалтад хамруулах;



11.10.5.өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрэх тээврийн хэрэгсэл, ажилтан, тэдгээрийн авч яваа эд зүйлсийн 20-оос доошгүй хувийг сонгож гараар шалгах;

11.10.6.нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд хамаардаггүй хэсгийг өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсээр тогтоож, тус бүсэд нэвтрэх ажилтнууд, тэдгээрийн эд зүйлс, тээврийн хэрэгслийг сонгож гараар шалгах;

11.10.7.аюулгүйн хамгаалалттай болон нийтийн эзэмшлийн бүсийн хоорондын заагт байнгын харуул хамгаалалт ажиллуулах;

11.10.8.зорчигч, үдэн гаргагч, угтагчдын бөөгнөрлийг бий болгохгүй байх, нисэх буудлын харуул, хамгаалалтыг нэмэгдүүлэх, нисэх буудал орчмын бүсийг хяналтад авах;

11.10.9.Ерөнхий газраас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ авах.

11.11.Иргэний нисэхийн эсрэг заналхийллийн Гуравдугаар түвшний үед энэ журмын 11.6-д зааснаас гадна дараах нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлнэ:

11.11.1.зорчигчийг агаарын хөлөгт нэвтрүүлэх, тээш, ачаа, шуудан, илгээмжийг ачихаас өмнө бүх агаарын хөлгийг аюулгүйн хамгаалалтын шалгалтад хамруулах;

11.11.2.агаарын хөлөгт нэвтрэх үндсэн хаалга тус бүрд аюулгүйн хамгаалалтын ажилтнаас гадна 2 хүний бүрэлдэхүүнтэй эргүүл ажиллуулж, агаарын хөлөгт нэвтрэх ажилтан, түүний эд зүйлсийг гараар шалгах;

11.11.3.агаарын хөлөгт нэвтрүүлэхээс өмнө явах бүх зорчигч, тэдгээрийн гар тээш, эд зүйлд хүзүүвчний гарц дээр аюулгүйн үзлэг, шалгалтыг дахин хийх;

11.11.4.аюулгүйн үзлэг, шалгалтад хамрагдсан явах зорчигчдыг ирж байгаа зорчигчдоос тусгаарлах;

11.11.5.бүх тээшийг агаарын хөлөгт ачихаас өмнө боломжит сүүлийн үеийн техник, технологи ашиглан аюулгүйн үзлэг, шалгалт хийх;

11.11.6.аюулгүйн үзлэг, шалгалт хийгдсэн тээшийг аюулгүйн хамгаалалтын ажилтны байнгын хяналтад байлгаж, лацтай чингэлэгт тээвэрлэж, баталгаажуулах;

11.11.7.зохицуулалттай агаарын ачааны байгууллага, тогтмол илгээгчийн ачаа барааг оролцуулан бүх ачаа, шуудан, илгээмжийг агаарын хөлөгт ачихаас өмнө аюулгүйн үзлэг, шалгалтад хамруулах;

11.11.8.агаарын тээвэрлэгчийн ажилтан нислэгийн үед хэрэглэх эд зүйлс болон нислэгийн хоол хүнсийг бэлтгэх, аюулгүйн үзлэг, шалгалт хийх, лацдахад байлцаж, агаарын хөлөг хүртэл дагалдаж, баталгаажуулах;

11.11.9.аюулгүйн хамгаалалттай болон өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд нэвтрүүлэхээс өмнө бүх тээврийн хэрэгсэл, ажилтан, тэдгээрийн авч яваа эд зүйлсийг гараар шалгах;

11.11.10.аюулгүйн хамгаалалттай болон нийтийн эзэмшлийн бүсийн хоорондын зааг, нисэх буудлын хашаа, хамгаалалтын бүсэд хяналт болон эргүүлийг нэмэгдүүлэх;

11.11.11.нисэх буудлын нийтийн эзэмшлийн бүсэд нэвтрэх хяналтыг тогтоох;

11.11.12.Ерөнхий газраас шаардлагатай гэж үзсэн бусад арга хэмжээ авах.

11.12.Нисэх буудал нь агаарын хөлөг хөөрөх, буух үед нисэх буудлын гадна байрлалаас халдлага хийж болзошгүй газрыг цагдаагийн байгууллагатай хамтран тогтоож, ээлжит бус шалгалтыг тухай бүр хийнэ.

Арван хоёр.Хөндлөнгийн хууль бус үйлдлийн эсрэг авах арга хэмжээ

12.1.Тагнуулын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан, эсхүл иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтад нөлөөлж болзошгүй хөндлөнгийн хууль бус үйлдлийн талаар авсан мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, энэ талаар холбогдох этгээдэд боломжит хэлбэрээр тухай бүр дамжуулах, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх асуудлыг хариуцна.

12.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдлийг газар дээр нь зохицуулах асуудлыг Монгол Улсын Терроризмтой тэмцэх зөвлөл хариуцна.



12.3.Хууль сахиулах, онцгой байдлын болон холбогдох бусад байгууллага нь хөндлөнгийн хууль бус үйлдэл гарсан тохиолдолд агаарын тээвэрлэгч, нисэх буудалтай хамтран нисэх буудлын онцгой нөхцөлийн төлөвлөгөөний дагуу ажиллана.

12.4.Нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт хөндлөнгийн хууль бус үйлдэл гарсан тохиолдолд тухайн агаарын тээвэрлэгч нь холбогдох мэдээллийг цуглуулж, энэ тухай нислэгийн маршрутын дагуух нислэгийн мэдээллийн бүсийг хариуцаж байгаа нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага болон агаарын зайн аюулгүй байдлын хяналтыг гүйцэтгэх үүрэг бүхий цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

12.5.Хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн агаарын хөлөгт агаарын навигацийн болон нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлнэ.

12.6.Нислэг үйлдэж байгаа агаарын хөлөгт хөндлөнгийн хууль бус үйлдэл гарсан тохиолдолд тухайн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг гүйцэтгэж байгаа байгууллага болон агаарын зайн аюулгүй байдлын хяналтыг гүйцэтгэх үүрэг бүхий цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагад нэн даруй мэдэгдэж, уг агаарын хөлгийн байршлын талаарх бодит мэдээллийг авах, радиолокаторын байнгын хяналтад байлгах арга хэмжээ авна.

12.7.Хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн агаарын хөлгийг Монгол Улсын нутаг дэвсгэрт газардахыг зөвшөөрч болох бөгөөд энэ тохиолдолд хууль сахиулах, онцгой байдлын болон холбогдох бусад байгууллага газардсан агаарын хөлгийг нисгэхгүй байх бүхий л арга хэмжээ авна.

12.8.Ерөнхий газар нь хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн агаарын хөлөг Монгол Улсын нутаг дэвсгэрт буусан тохиолдолд Олон улсын иргэний нисэхийн байгууллагад батлагдсан маягтын дагуу нэн даруй мэдэгдэнэ.

12.9.Ерөнхий газар хөндлөнгийн хууль бус үйлдэл гарсан, түүнтэй холбоотой хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний талаар дараах тайланг доор дурдсан хугацаанд Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэнэ:

12.9.1.урьдчилсан тайланг тухайн үйл явдал болсноос хойш 30 хоногийн дотор;

12.9.2.эцсийн тайланг тухайн үйл явдал болсноос хойш 60 хоногийн дотор.

12.10.Ерөнхий газар нь агаарын хөлөг хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн тухай тагнуулын байгууллагын мэдээ, мэдээллийн дагуу агаарын тээвэрлэгчид мэдэгдэх бөгөөд тухайн агаарын тээвэрлэгч нь агаарын хөлөгт нуусан зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, аюултай хэрэгсэл, эд зүйлсийг илрүүлэх шалгалт хийх үүрэгтэй.

12.11.Хөндлөнгийн хууль бус үйлдэлд өртсөн агаарын хөлөг Монгол Улсын нутаг дэвсгэрт газардсан тохиолдолд хууль сахиулах, онцгой байдлын болон холбогдох бусад байгууллага тухайн агаарын хөлөг аяллаа цааш үргэлжлүүлэх хүртэл хугацаанд зорчигч, нисэх бүрэлдэхүүний аюулгүйн хамгаалалтыг хангах арга хэмжээ авна.

12.12.Хил хамгаалах байгууллага нь хилийн боомт бүхий олон улсын нисэх буудалд хөндлөнгийн хууль бус үйлдэл, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, хүн, тээврийн хэрэгсэл барьцаалсан, террорист үйлдлийн эсрэг сөрөг тусгай ажиллагааны үед зэвсэг, галт хэрэглэл, биеийн хүч хэрэглэнэ. Хилийн боомт бүхий олон улсын нисэх буудалд зэвсэг, галт хэрэглэл, тусгай хэрэгслийг тусгайлан төхөөрөмжилсөн газарт байрлуулна.

Арван гурав.Хяналт тавих

13.1.Ерөнхий газар нь иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын хяналтыг хэрэгжүүлэх ажилтныг энэ журмын зохих шаардлагын дагуу сонгон шалгаруулж, сургалтад хамруулах ба холбогдох бүртгэлийг хөтөлж, тухай бүр шинэчилнэ.

13.2.Иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын хяналтыг хэрэгжүүлэх, нисэх буудлын өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд дагалдах хүнгүй нэвтрэх, нисэхийн аюулгүйн хамгаалалтын чухал мэдээлэлд нэвтрэх ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж эхлэх, эсхүл өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд болон чухал мэдээлэлд нэвтрэхийн өмнө анкет шалгалт хийнэ.

13.2.1.Анкет шалгалтын явцад шалгуулагч нь дараах төрлийн гэмт хэрэгт шийтгэгдэж байсан нь тогтоогдсон бол анкет шалгалтад тэнцээгүйд тооцно:

13.2.1.1.мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм хэрэглэх, хадгалах;



худалдах; 13.2.1.2.мансууруулах бодис, хар тамхи

худалдах; 13.2.1.3.галт зэвсэг хууль бусаар эзэмших,

байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэх, оролцох; 13.2.1.4.хүчирхийлэл, нийгмийн аюулгүй

сонирхлын эсрэг гэмт хэрэг үйлдэх, оролцох; 13.2.1.5.олон нийтийн аюулгүй байдал, ашиг

үйлдэл хийх; 13.2.1.6.иргэний нисэхийн эсрэг хууль бус

гишүүн байх; 13.2.1.7.ямар нэгэн гэмт хэргийн бүлэглэлийн

13.2.1.8.хилийн боомтод мөрдөх журам зөрчих.

13.3.Анкет шалгалтын мэдээллийг 2 жил тутам шалгаж, шинэчилнэ. Анкет шалгалтын явцад бүрдүүлсэн шалгуулагчийн хувийн мэдээлэл, өргөдөл, түүнд хавсаргасан бичиг баримтын бүртгэлийг хөтөлж, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангаж, хадгална.

13.4.Анкет шалгалтад тэнцээгүй ажилтанд аюулгүйн хамгаалалтын хяналт тавьж, өндөржүүлсэн аюулгүйн хамгаалалттай бүсэд дагалдах хүнгүй нэвтрэх, нисэхийн аюулгүйн хамгаалалтын чухал мэдээлэлд нэвтрэх эрх олгохоос татгалзана.

13.5.Иргэний нисэхийн аюулгүйн үзлэг, шалгалт хийх ажилтан нь батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтад хамрагдаж, тусгай журмын дагуу мэргэжлийн үнэмлэх авсан байна.

13.6.Нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага, зохицуулалттай ачаа зуучлалын байгууллага болон иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ эрхлэх байгууллага нь иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын сургалтын бодлогын баримт бичигт нийцсэн сургалтын хөтөлбөрийг Ерөнхий газраар баталгаажуулан, хэрэгжүүлнэ.

13.7.Ерөнхий газар тогтоосон хугацаанд энэ журмын хэрэгжилтэд аудит, үзлэг, шалгалт, сорилт хийх ба журамд нийцээгүй асуудлыг богино хугацаанд залруулах арга хэмжээг зохих сургалтад хамрагдсан, мэргэшсэн, чадварлаг ажилтнаар гүйцэтгүүлнэ.

13.8.Ерөнхий газар нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ эрхлэх байгууллага, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага, зохицуулалттай ачаа зуучлалын байгууллагын болон нислэгийн хоол хүнс бэлтгэх байгууллагын аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд тодорхой давтамжтай үзлэг, шалгалт хийж, дутагдлыг цаг алдалгүй арилгуулах арга хэмжээ авна.

13.9.Иргэний нисэхийн эсрэг хөндлөнгийн хууль бус үйлдлийн эсрэг хариу арга хэмжээний хэсэгчилсэн дасгал, сургуулилалтыг жилд нэгээс доошгүй удаа, бүрэн хэмжээний дасгал, сургуулилалтыг хоёр жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.

13.10.Ерөнхий газар тогтоосон хугацаанд аюулгүйн хамгаалалтын арга хэмжээний хэрэгжилт энэ журамд нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах бөгөөд холбогдох эрх бүхий байгууллагаас хийх эрсдэлийн үнэлгээнд үндэслэн хийх хяналтын арга хэмжээ, давтамжийг тодорхойлно.

13.11.Ерөнхий газар хөндлөнгийн хууль бус үйлдэл гарсан тохиолдолд аюулгүйн хамгаалалтын хяналт, журмыг дахин үнэлж, уг үйлдэл давтагдан гарахаас урьдчилан сэргийлэх, хохирлыг арилгахад шаардлагатай арга хэмжээ авч, Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдэгдэнэ.

13.12.Ерөнхий газар нисэхийн аюулгүйн хамгаалалтын сургалтын хөтөлбөрийг боловсруулах, зааварлагчийг мэргэшсэн болохыг баталгаажуулах, үнэмлэхжүүлэх тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлнэ.

13.13.Ерөнхий газар нь энэ журмын дагуу нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах үүрэг хүлээсэн ажилтанд зориулсан сургалтын бүх хөтөлбөрт анхан болон давтан сургалтаар ур чадварыг эзэмшүүлэх, хадгалах, үнэлэх талаар тусгаж, баталгаажуулна.

13.14.Ерөнхий газар нь нисэх буудал, агаарын тээвэрлэгч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний байгууллага, зохицуулалттай ачаа зуучлалын байгууллага болон иргэний нисэхийн аюулгүйн хамгаалалтын үйлчилгээ эрхлэх байгууллагын үйл ажиллагаанд хийх аюулгүйн хамгаалалтын сорилтод ашиглах эд зүйл, хэрэгслийг баталгаажуулж, сорилтыг улирал тутам хийнэ.

Арван дөрөв.Аюулгүйн хамгаалалтын санхүүжилт

14.1.Энэ журамд заасны дагуу нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангах үүрэг хүлээсэн байгууллага хариуцсан үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүр байгууллагын төсөвтөө тусгана.

---о0о---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 215

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 24.1.1, 24.1.11, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15.6-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолын 1-д заасан журмыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж, зарцуулалтад нь хяналт тавьж, удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын сайд П.Наранбаярт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Их, дээд сургуулийг “Сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн цогцолбор” болгон орон нутагт хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 321 дүгээр тогтоолын 2 дахь заалт, “Журам шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 102 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

БОЛОВСРОЛЫН САЙД

П.НАРАНБАЯР

[illegible]



Засгийн газрын 2025 оны 04 дүгээр
сарын 30-ны өдрийн 215 дугаар
тогтоолын хавсралт

**ДЭЭД БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН СУРАЛЦАГЧИД
ТЭТГЭЛЭГ, ЗЭЭЛ, БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ, ДЭМЖЛЭГ
ҮЗҮҮЛЭХ, ЗЭЭЛ ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллага (цаашид “сургалтын байгууллага” гэх)-ын суралцагчид тэтгэлэг, сургалтын зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, сургалтын зээлийг эргэн төлүүлэхтэй холбогдох харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Суралцагчийн тэтгэлэг, сургалтын зээл, буцалтгүй тусламж, дэмжлэг үзүүлэх, сургалтын зээлийг эргэн төлүүлэх үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэ журмыг баримтална.

1.3.Энэ журамд хэрэглэсэн нэр томъёог доор дурдсан утгаар хэрэглэнэ:

1.3.1.“тэтгэлэг” гэж Дээд боловсролын тухай хуулийн 4.1.5-д заасан мөнгөн тусламжийг;

1.3.2.“зээл” гэж Дээд боловсролын тухай хуулийн 4.1.6-д заасан эргэн төлөгдөх, хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох мөнгөн хөрөнгийг;

1.3.3.“буцалтгүй тусламж” гэж энэ журмын дагуу суралцагчид олгох эргэн төлөх нөхцөлгүй сургалтын төлбөрийн зардлыг;

1.3.4.“сургалтын төлбөрийн хөнгөлөлт” гэж Дээд боловсролын тухай хуулийн 4.1.7-д заасан сургалтын төлбөрөөс тодорхой хувиар чөлөөлөхийг;

1.3.5.“бэлтгэл хөтөлбөр” гэж Дээд боловсролын тухай хуулийн 20.6-д заасан боловсролын зэрэг олгох хөтөлбөрт хамрагдахын өмнө заавал судлах нөхцөлтэй сургалтын хөтөлбөрийг;

1.3.6.“сан” гэж Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.1-д заасан Боловсролын зээлийн санг;

1.3.7. “2+2 хөтөлбөр” гэж дотоодын их, дээд сургуулиудын хөгжлийг дэмжих, бакалаврын түвшинд бэлтгэх хүний нөөц, сургалтын зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Дээд боловсролын тухай хуулийн 31.2-т заасан хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийг;

1.3.8. “амьжиргааны зардал” гэж суралцагчийн дотуур байрны болон хүнсний зардлыг.

1.4. Суралцагчид тэтгэлэг, сургалтын зээл, буцалтгүй тусламж, хөнгөлөлт олгох, сургалтын зээлийг эргэн төлүүлэх үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий хуулийн 5.1-д заасан зарчмыг баримтална.

1.5. Монгол Улсаас гадаадын сургалтын байгууллагад, эсхүл гадаад улсаас Монгол Улсын сургалтын байгууллагад суралцах суралцагчийн мэргэжил болон сургалтын төлбөрийн хэмжээг тухайн улсын Засгийн газар, эсхүл байгууллага хооронд байгуулсан гэрээнд зааснаар зохицуулна. Гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаадад суралцах суралцагчид олгох сургалтын төлбөрийг нэхэмжилсэн дүнгийн хэмжээгээр тооцно.

1.6. Гадаад улсад суралцагчид олгох амьжиргааны зардлын тухайн жилд олгох хэмжээг Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газраас ирүүлсэн судалгаанд үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн жил бүрийн 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор батална.

1.7. Гадаадын сургалтын байгууллагад тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр тэтгэлэгтэй суралцахад Засгийн газраас баталсан тэргүүлэх, эрэлттэй мэргэжлийн чиглэлийн хөтөлбөрийг баримтална.

1.8. Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн суралцагчийг суралцуулах хяналтын тоог тухайн жилийн батлагдсан төсөвтөө багтаан жил бүрийн 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор дараах байдлаар тогтооно:

1.8.1. дотоодын сургалтын байгууллагад суралцагчид хөнгөлөлт, тэтгэлэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл олгох;

1.8.2. дээд боловсролын түвшин тус бүрээр гадаадын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл олгох.

1.9. Энэ журмын 1.8-д заасан хяналтын тоонд хөгжлийн бэрхшээлтэй суралцагч хамаарахгүй.



**Хоёр.Тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж, дэмжлэг
олгох суралцагчид тавих нийтлэг шаардлага**

2.1.Тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж, дэмжлэг авах дотоодын сургалтын байгууллагын суралцагч дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

2.1.1.Монгол Улсын иргэн байх;

2.1.2.тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлийн үндсэн хөтөлбөрт элсэн суралцагч байх;

2.1.3.боловсролын цахим мэдээллийн системд бүртгэгдсэн байх;

2.1.4.магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөр, эсхүл сургалтын байгууллагын үндэсний эрэмбийн үнэлгээний “сургалт” хэсэгт 50-аас дээш хувийн үнэлгээ авсан сургалтын байгууллагад суралцдаг байх;

2.1.5.дэд бакалавр, бакалавр, магистр, докторын хөтөлбөрт анхлан суралцагч байх;

2.1.6.суралцагч зээл авснаас бусад тохиолдолд сангийн хөрөнгөөр суралцаагүй байх;

2.1.7.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу “Өрийн мэдээллийн нэгдсэн сан”-д зээлийн үлдэгдэлгүй байх.

2.2.Гадаадын сургалтын байгууллагын суралцагч дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

2.2.1.Монгол Улсын иргэн байх;

2.2.2.тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр үндсэн хөтөлбөрт элсэн суралцагч байх;

2.2.3.магистр, докторын хөтөлбөрт анхлан суралцагч байх;

2.2.4.суралцагч зээл авснаас бусад тохиолдолд сангийн хөрөнгөөр суралцаагүй байх;

2.2.5.элсэн суралцагч бол үндсэн хөтөлбөрөөр суралцах шаардлага хангаж, урилга авсан, үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улирлын голч дүнгийн авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй байх;

2.2.6.Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу “Өрийн мэдээллийн нэгдсэн сан”-д зээлийн үлдэгдэлгүй байх.

Гурав.Бүрдүүлэх баримт бичиг, сонгон шалгаруулалт

3.1.Дотоодын сургалтын байгууллагад тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж, хөнгөлөлтөөр суралцахаар хүсэлт гаргагч нь дараах баримт бичгийг бүрдүүлж бичгээр, эсхүл цахим хэлбэрээр тухайн сургалтын байгууллагадаа хүргүүлнэ:

3.1.1.хүсэлт (батлагдсан маягтаар);

3.1.2.иргэний үнэмлэх (лавлагаа);

3.1.3.дэд бакалавр, бакалаврын үндсэн хөтөлбөрт элсэгч бол элсэлтийн шалгалтын батламжийн хуулбар, техникийн боловсролын сургалтын байгууллагын төгсөгч бол дипломын хуулбар, магистр, докторын үндсэн хөтөлбөрт элсэгч бол өмнөх боловсролын зэргийн дипломын хуулбар;

3.1.4.үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улирлын голч дүнгийн хуудас, тухайн улиралд судлах хичээлийг баталгаажуулсан сургалтын байгууллагын тодорхойлолт;

3.1.5.зорилтот бүлгийн суралцагч бол хувийн байдлыг тодорхойлох эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

3.1.6.сургалтын төлбөрийн нэхэмжлэл.

3.2.Гадаадын сургалтын байгууллагад тэтгэлэг болон зээлээр суралцах хүсэлт гаргагч дараах баримт бичгийг бүрдүүлж, цаасаар, эсхүл цахим хэлбэрээр санд хүргүүлнэ:

3.2.1.хүсэлт (батлагдсан маягтаар);

3.2.2.иргэний үнэмлэх (лавлагаа);

3.2.3.тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах бол ажилласан жилийг тодорхойлсон албан бичиг;



3.2.4.докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах бол эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт, тодорхойлох захидал (суралцах арга барил, судалгааны урьдчилсан сэдэв, арга зүй, эрдэм шинжилгээний ажлын туршлага, зан төлөвийн онцлогийг тодорхойлсон удирдагч багш, эрдэмтэн, байгууллага тус бүрийн тодорхойлолт);

3.2.5.цагдаагийн байгууллагын тодорхойлолт (гадаадын сургалтын байгууллагад суралцагч);

3.2.6.энэ журмын 4.2.2-т заасан суралцагч бол олимпиадад оролцож медальт байрт шалгарсныг гэрчлэх баримт бичгийн хуулбар;

3.2.7.сургалтын төлбөрийн нэхэмжлэхийн хуулбар;

3.2.8.төрийн албан хаагч бол ажлын гүйцэтгэлийн үнэлгээний хуудас болон ажилласан жилийг тодорхойлсон албан бичиг;

3.2.9.гадаадын сургалтын байгууллагын үндсэн ангид нэмэлт нөхцөлгүйгээр суралцах эрхийг авсан байх.

3.3.Ажлын хэсэг тухайн суралцагчийн зөвшөөрөлтэйгөөр иргэний үнэмлэх, боловсролын баримт бичиг, цагдаагийн байгууллагын тодорхойлолт болон бусад баримт бичгийг төрийн үйлчилгээний “И-Монгол” цахим системээс нэмэлтээр авч болно. Ажлын хэсэг суралцагчид тавьж буй шаардлага хангасан эсэх талаар нэмэлт тодруулгыг холбогдох байгууллагаас ажлын 5 өдрийн дотор авч болно.

3.4.Тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж, хөнгөлөлтөөр дотоодын сургалтын байгууллагад суралцуулах сонгон шалгаруулалтыг жил бүрийн I, III улиралд, гадаадын сургалтын байгууллагад суралцуулах сонгон шалгаруулалтыг жил бүрийн II улиралд багтаан цахимаар зохион байгуулна.

3.5.Сонгон шалгаруулалтын зарыг хүсэлт хүлээн авах хугацаанаас хуанлийн 30-аас доошгүй өдрийн өмнө боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, сан болон сургалтын байгууллагын цахим хуудсаар нээлттэй зарлана.

3.6.Тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжид хамрагдах хүсэлтийг сонгон шалгаруулалтын зарын дагуу тогтоосон хугацаанд дотоодын сургалтын байгууллагад суралцах бол тухайн сургалтын байгууллагад, гадаадын сургалтын байгууллагад суралцах бол санд гаргана.

3.7.Дотоодын сургалтын байгууллага хүсэлт ирүүлсэн суралцагчийн баримт бичгийг хүсэлт хүлээн авах хугацаа дууссанаас хойш хуанлийн 30 өдрийн дотор хянаж, тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжид хамрагдах шаардлага хангасан суралцагчийн нэрсийг хяналтын тоонд багтаан санд хүргүүлнэ. Сан ирүүлсэн мэдээллийг хянаж, баталгаажуулна.

3.8.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр гадаадын сургалтын байгууллагад суралцах суралцагчийн сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг (цаашид “Ажлын хэсэг” гэх)-ийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, холбогдох төрийн захиргааны төв байгууллага болон сан, их, дээд сургууль, төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүний 50-аас доошгүй хувь нь төрийн болон хувийн өмчийн их, дээд сургууль, төрийн бус байгууллага болон мэргэжлийн холбооны төлөөлөл байна.

3.9.Ажлын хэсгийн ажиллах удирдамжийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Ажлын хэсгийн удирдамжаар ажлын хэсгийн дотоод зохион байгуулалт болон шалгаруулалттай холбоотой санал, хүсэлтийг зохицуулна.

3.10.Ажлын хэсэг энэ журмын 5.3.1-д заасан төрийн албан хаагчаас бусад гадаадын сургалтын байгууллагад суралцах суралцагчийн баримт бичгийн бүрдлийг сонгон шалгаруулалтын материал хүлээж авах хугацаа дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хяналтын тоонд багтаан шаардлага хангасан суралцагчийг дараах шалгуурыг үндэслэн 100 хүртэл оноогоор үнэлж жагсаана:

3.10.1.дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Таймс Хайэр Эдүкейшн Верлд Университи Ранкингс”-аас цаг хугацааны хувьд хамгийн сүүлд тогтоосон эрэмбийн жагсаалтыг үндэслэн 25 хүртэл оноо;

3.10.2.тэтгэлгийн хэмжээг үндэслэн 40 хүртэл оноо;

3.10.3.сургалтын төлбөрийн нийт хэмжээнээс хамаарч 35 хүртэл оноо.

3.11.Шалгаруулалтад оролцогчийн нийт оноо тэнцсэн тохиолдолд тухайн суралцагчийн суралцах сургалтын байгууллагаас олгох тэтгэлгийн хэмжээ, сургалтын байгууллагын эрэмбэ, сургалтын төлбөрийн хэмжээ гэсэн дарааллын дагуу шийдвэрлэнэ.



3.12.Ажлын хэсэг сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор сонгон шалгаруулалтын тайлан, хяналтын тоонд багтсан суралцагчийн нэрсийн жагсаалт, түүнд холбогдох баримт бичгийг санд хүлээлгэн өгнө.

3.13.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын 2 өдрийн дотор хяналтын тоонд багтаан нэрсийг баталгаажуулах бөгөөд шийдвэрийг суралцагчид цахим шуудан, эсхүл утсаар мэдэгдэж, цахим хуудсаар олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлнэ.

3.14.Суралцагч сонгон шалгаруулалтын дүнг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд сангийн дэргэдэх Орон тооны бус зөвлөлд гомдол гаргаж болно.

3.15.Орон тооны бус зөвлөлд гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянаж, дүгнэлт гаргана. Шаардлагатай тохиолдолд энэ хугацааг ажлын 3 хүртэл өдрөөр нэг удаа сунгаж болно.

3.16.Ажлын хэсэг Орон тооны бус зөвлөлийн дүгнэлтийг харгалзан энэ журмын 3.15-д зааснаас гадна холбогдох хуулийн хүрээнд гомдлыг шийдвэрлэнэ.

Дөрөв.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг

4.1.Монгол хүн бүрийг чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор бүрэн хангаж, орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах, эх оронч сэтгэлтэй, зөв хандлагатай, олон улсад өрсөлдөх мэдлэг, чадвартай, бүтээлч, манлайлагч иргэнийг бэлтгэх зорилгоор тухайн жилийн сонгон шалгаруулалтад тэнцсэн 500 хүртэлх суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг олгоно.

4.2.Ерөнхийлөгчийн тэтгэлэг дараах төрөлтэй байна:

4.2.1.Монгол Улсын бүх сум, хорооны түвшинд шалгарсан суралцагчид олгох бэлтгэл болон үндсэн хөтөлбөрийн тэтгэлэг;

4.2.2.олон улсын олимпиадад медальт байранд шалгарсан суралцагчид олгох тэтгэлэг.

4.3.Энэ журмын 4.2.1-д заасан бэлтгэл хөтөлбөрт элсэгч дараах шаардлага хангасан байна:

4.3.1.сүүлийн 3-аас доошгүй жил ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойргийн дагуу харьяалагдах сум, хороондоо

суралцаж төгссөн байх, ахлах сургуульгүй сумын суралцагч бол харьяалагдах аймгийн аль нэг ердийн сургалттай сургуульд тасралтгүй 3-аас доошгүй жил суралцсан байх;

4.3.2. тухайн жилийн элсэлтийн шалгалтын “гадаад хэл-математик”, “гадаад хэл-физик”, “гадаад хэл-хими”, “гадаад хэл-биологи” гэсэн хувилбарын хэмжээст онооны дунджаар 550, түүнээс дээш оноо авсан байх;

4.3.3. энэ журмын 4.3.2-т заасан хэмжээст онооны дунджаар хамгийн өндөр оноо авч, сум, хороондоо тэргүүлсэн байх.

4.4. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагын шийдвэрээр хамран сургах тойргийг өөрчилсөн бол энэ журмын 4.3.1-д заасан хугацааны шаардлага хамаарахгүй.

4.5. Суралцагч англи хэл, орос хэлний хичээлийн элсэлтийн шалгалтыг зэрэг өгсөн тохиолдолд аль өндөр оноо авсан гадаад хэлний хичээлийн шалгалтын оноогоор тооцно.

4.6. Энэ журмын 4.2.1-д заасан үндсэн хөтөлбөрийн тэтгэлэгт хамрагдах суралцагч дараах шаардлага хангасан байна:

4.6.1. тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрийг 60, түүнээс дээш хувийн үнэлгээтэй төгссөн байх;

4.6.2. дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тухайн жилд тогтоосон эрэмбийн жагсаалтын эхний 20-д багтсан сургалтын байгууллагад (Таймс Хайэр Эдүкейшн Вөрлд Университи Ранкингс) бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол мэргэжил харгалзахгүй, 21-100-д багтсан сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцах;

4.6.3. энэ журмын 4.9-д заасан тухайн гадаадын сургалтын байгууллагын шаардлага хангасан байх.

4.7. Энэ журмын 4.2.2-т заасан тэтгэлэгт хамрагдах суралцагч олон улсын олимпиадын хорооноос зохион байгуулдаг хиймэл оюун, математик, физик, хими, биологи, газарзүй, мэдээлэл зүйн хичээлийн олимпиадад сүүлийн 3 жил медальт байранд шалгарсан байх шаардлагыг хангасан тохиолдолд энэ журмын 4.13.3-т заасан хугацаанд ирүүлсэн материалд үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн суралцах эрхийг баталгаажуулна.



4.8.Энэ журмын 4.2.1-д заасан бэлтгэл хөтөлбөрийн сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх дотоодын сургалтын байгууллага дараах шаардлага хангасан байна:

4.8.1.байгууллагын магадлан итгэмжлэлийн хугацаа хүчин төгөлдөр байх;

4.8.2.математик, байгалийн шинжлэх ухаан, гадаад хэлний мэргэжлийн чиглэлээр хөтөлбөр хэрэгжүүлдэг байх;

4.8.3.боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх гэрээ байгуулсан байх.

4.9.Энэ журмын 4.2.1-д заасан тэтгэлгээр суралцагчийг Засгийн газар хоорондын болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, сангаас хийсэн хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хүрээнд гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцуулна.

4.10.Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, холбогдох төрийн байгууллага, иргэн, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн 11 гишүүний бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг байгуулж, тэтгэлгийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулна.

4.11.Тэтгэлгийн сонгон шалгаруулалт бэлтгэл болон үндсэн хөтөлбөрийн гэсэн үе шаттай байна.

4.12.Ажлын хэсэг бэлтгэл хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг тухайн жилийн III улиралд багтаан дараах байдлаар зохион байгуулна:

4.12.1.боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага элсэлтийн шалгалт зохион байгуулагдсаны дараа энэ журмын 4.3-т заасан шаардлага хангасан суралцагчийн нэрсийн жагсаалтыг сум, хороо бүрээр гаргаж, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн болон улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тухайн жилийн 07 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлнэ;

4.12.2.энэ журмын 4.12.1-д заасан нэрсийн жагсаалтын дагуу хамран сургах тойргийн шийдвэрт үндэслэн сургууль, сум, хороо бүрээр хянаж баталгаажуулсан мэдээллийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, суралцагч, түүний эцэг, эх, асран хамгаалагчийн оршин суугаа хаяг, сүүлийн 3 жилд шилжилт хөдөлгөөн хийсэн эсэх мэдээллийг улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага ажлын 3 өдөрт багтаан боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагад тус тус хүргүүлнэ;

4.12.3.энэ журмын 4.12.2-т заасны дагуу улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн мэдээллийг Боловсролын мэдээллийн технологийн төвд хүргүүлэх бөгөөд тус байгууллага суралцагчийн хаягийн бүртгэлийн мэдээлэлд үндэслэн түүний сүүлийн 3 жил сурсан сургуулийн мэдээллийг ажлын 3 өдөрт багтаан боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллагад хүргүүлнэ;

4.12.4.боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага энэ журмын 4.12.2, 4.12.3-т заасны дагуу холбогдох байгууллагаас ирүүлсэн суралцагчийн мэдээллийг хянаж, баталгаажуулсан нэрсийн жагсаалтыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тухайн жилийн 08 дугаар сарын 05-ны өдрийн дотор хүргүүлнэ;

4.12.5.боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэрсийн жагсаалтын дагуу ажлын 2 өдрийн дотор бэлтгэл хөтөлбөрт хамрагдах суралцагчийн нэрсийг гаргаж Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт албан бичгээр хүргүүлнэ;

4.12.6.боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ажлын 5 өдөрт багтаан энэ журмын 4.12.5-д заасан суралцагчийн суралцах гадаад хэл, мэргэжлийн чиглэлийн дагуу холбогдох сургалтын байгууллагад хуваарилалт хийж хүргүүлнэ;

4.12.7.бэлтгэл хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын байгууллага ажлын 10 өдрийн дотор энэ журмын 4.12.6-д заасан хуваарийн дагуу суралцагчаас санал авч баталгаажуулан, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ;

4.12.8.боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр энэ журмын 4.10.7-д заасан бэлтгэл хөтөлбөрт хамрагдах суралцагчийн нэрсийг ажлын 3 өдрийн дотор эцэслэн баталгаажуулж, сан, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын цахим хуудсаар нээлттэй, ил тод мэдээлнэ;

4.12.9.суралцагч бэлтгэл хөтөлбөр эхлэхийн өмнө суралцахаас татгалзсан тохиолдолд тухайн орон нутгаас түүний дараагийн шаардлага хангасан суралцагчийг элсүүлж болно. Бэлтгэл хөтөлбөр эхэлснээс хойш суралцагчийг нөхөн элсүүлэхгүй;

4.12.10.суралцагч бэлтгэл хөтөлбөрийн үргэлжлэх хугацаанд эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар суралцах боломжгүй болсон тохиолдолд сонгон шалгаруулалтыг дахин зохион байгуулахгүй;



4.12.11.бэлтгэл хөтөлбөрийн үргэлжлэх хугацаа хичээлийн 1 жил байна. Суралцагч англи хэлнээс бусад гадаад хэлээр суралцах тохиолдолд шаардлагатай гэж үзвэл үндсэн хөтөлбөрт хамаарах бэлтгэл хөтөлбөрт хичээлийн 1 хүртэл жилд дахин суралцаж болно;

4.12.12.бэлтгэл хөтөлбөрийн эхний улиралд амжилттай суралцсан суралцагчид дараа оны I улиралд Монгол Улсын Ерөнхийлөгчийн илгээлт (батламж)-ийг гардуулна.

4.13.Ажлын хэсэг үндсэн хөтөлбөрийн сонгон шалгаруулалтыг тухайн жилийн II улиралд багтаан дараах байдлаар зохион байгуулна:

4.13.1.суралцагч бэлтгэл хөтөлбөрт 60 хувиас доош үнэлэгдсэн тохиолдолд энэ журмын 4.10-д заасан тэтгэлэгт хөтөлбөрийн сонгон шалгаруулалтад оролцох боломжгүй бөгөөд суралцагчийг дотоодын сургалтын байгууллагад хувийн зардлаар үргэлжлүүлэн суралцах боломжоор хангана;

4.13.2.үндсэн хөтөлбөрийн сонгон шалгаруулалтын мэдээллийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон сан бэлтгэл хөтөлбөрийн суралцагчид нээлттэй хүргэнэ;

4.13.3.суралцагч энэ журмын 3.2-т заасан баримт бичгийг бүрдүүлж, тухайн жилийн 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад цахимаар хүргүүлнэ;

4.13.4.суралцагчийн сонгон шалгаруулалтын оноо тэнцүү үнэлэгдсэн тохиолдолд энэ журмын 4.2.1-д заасан тэтгэлэгт гадаадын сургалтын байгууллагын эрэмбэ, бэлтгэл хөтөлбөрийн сурлагын амжилт, элсэлтийн шалгалтын оноо, энэ журмын 4.2.2-т заасан тэтгэлэгт гадаадын сургалтын байгууллагын эрэмбэ, олимпиадад эзэлсэн байр, гадаад хэлний мэдлэгийн түвшнийг тус тус харгалзан хяналтын тоонд багтаан сонгон шалгаруулна;

4.13.5.Ажлын хэсэг суралцагчийн баримт бичгийн бүрдлийг материал хүлээн авч дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хянаж энэ журмын 4.4-т заасан шаардлага хангасан суралцагчид тэтгэлэг олгох санал, дүгнэлтийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд танилцуулна;

4.13.6.боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр тэтгэлэгт шалгарсан суралцагчийн нэрсийг ажлын

2 өдрийн дотор баталгаажуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт албан бичгээр хүргүүлнэ;

4.13.7.сонгон шалгаруулалтын дүнг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, сангийн цахим хуудсаар олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлнэ.

4.14.Энэ журмын 4.12.5, 4.12.8-д заасан жагсаалт батлагдсаны дараа цахим хуудсаар дамжуулан тухайн суралцагчид мэдэгдэж, нэрсийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар олон нийтэд зарлана.

4.15.Сан бэлтгэл хөтөлбөрт шалгарсан суралцагч болон суралцах сургалтын байгууллагатай гурван талт гэрээ, үндсэн хөтөлбөрийн суралцагч болон түүний харьяалагдах аймаг, нийслэлийн Засаг даргатай гурван талт гэрээ, энэ журмын 4.2.2-т заасан суралцагчтай хоёр талт гэрээг тус тус байгуулна.

4.16.Бэлтгэл хөтөлбөрийн суралцагчид сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох бөгөөд орон нутгаас ирсэн суралцагч бол дотуур байрны зардал нэмж олгож болно.

4.17.Тэтгэлгийн үндсэн хөтөлбөрийн суралцагчид сургалтын төлбөр, амьжиргааны зардал олгоно.

4.18.Энэ журмын 4.9-д заасан гэрээ, хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол гадаадын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөр, амьжиргааны зардлын тэтгэлгийг давхардуулахгүй олгоно.

4.19.Үндсэн хөтөлбөрт тэтгэлгээр суралцагчийг төгссөнөөс хойш 1 жилийн дотор түүний харьяалагдах аймаг, нийслэлийн Засаг дарга мэргэжлийн дагуу тухайн Засаг захиргаа, нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж, байгууллагад ажлын байраар хангах арга хэмжээ авах бөгөөд хөгжлийн бодлоготой уялдуулан төгсөгчийг өөр газарт томилон ажиллуулж болно. Төгсөгч нь аймаг (сумаас шалгарсан бол)-т, нийслэл (хорооноос шалгарсан бол)-д 5-аас доошгүй жил тогтвортой ажиллана.

4.20.Энэ журмын 4.2.2-т заасан суралцагч төгсөөд 1 жилийн дотор эх орондоо мэргэжлээрээ ажилд орсон байх бөгөөд 5-аас доошгүй жил тогтвортой ажиллана.

4.21.Энэ журмын 4.1-д заасан тэтгэлгээр суралцагч болон төгсөгч ерөнхий боловсролын сургууль болон бусад сургалтын байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, оролцох үүрэг хүлээнэ.



Тав.Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг

5.1.Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, олон улсад өрсөлдөх мэдлэг чадвартай, нийгэм, эдийн засаг, шинжлэх ухааны хөгжилд бодит хувь нэмрээ оруулах манлайлагчийг бэлтгэх зорилгоор дотоодын болон гадаадын сургалтын байгууллагад тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр эзэмших суралцагчид Засгийн газрын тэтгэлэг (цаашид “Засгийн газрын тэтгэлэг” гэх) олгоно.

5.2.Төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, манлайлах чадварыг хөгжүүлэх, төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн хүрээнд ажлын гүйцэтгэл, үр дүнгээр шалгарч, магистрын зэргийн өмнөх хэлний бэлтгэл, ахисан түвшний сургалтад суралцах албан хаагчид сангаас болон бусад эх үүсвэрээс тэтгэлэг олгоно.

5.3.Засгийн газрын тэтгэлэгт дараах иргэн хамрагдана:

5.3.1.магистрын зэргийн өмнөх бэлтгэл хөтөлбөр (хэлний бэлтгэл), магистр болон докторын хөтөлбөрөөр сургалтад суралцах төрийн албан хаагч;

5.3.2.тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр суралцагч;

5.3.3.техникийн боловсролын сургалтын байгууллагын олон улсын хөтөлбөрийг дотоодын сургуульд төгсөж, тухайн мэргэжлийн чиглэлээрээ гадаадын сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрөөр дэвшин суралцагч.

5.4.Төрийн албан хаагчийн магистрын зэргийн өмнөх хэлний бэлтгэл, ахисан түвшний сургалтад суралцах албан хаагч энэ журмын 2.2-т заасан нийтлэг шаардлага болон дараах тусгай шаардлага хангасан байна:

5.4.1.төрийн албанд 5-аас доошгүй жил, тухайн байгууллагад 3-аас доошгүй жил ажилласан үндсэн ажилтан байх;

5.4.2.төрийн албан хаагчийн хувьд сүүлийн 3 жилийн гүйцэтгэлийн үнэлгээгээр холбогдох журамд заасан хамгийн өндөр үнэлгээний ангилалд багтсан байх;

5.4.3.ажиллаж буй байгууллага захиалга өгсөн байх;

5.4.4.гадаадын сургалтын байгууллагад суралцан төгсөж ирээд 5 жил ажиллах боломжтой байх (өндөр насны болон

цэргийн тэтгэвэр тогтоолгох насны хязгаар, төрийн тусгай албаны 20-25 жил ажилласан байх нөхцөлөөс үлдсэн хугацаа 10 жилээс доошгүй байх).

5.5.Энэ журмын 5.3.2-т заасан дотоодын сургалтын байгууллагад суралцагч энэ журмын 2.1-д заасан нийтлэг шаардлага болон дараах тусгай шаардлага хангасан байна:

5.5.1.дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцагч байх;

5.5.2.дэд бакалавр хөтөлбөрт элсэн суралцагч бол элсэлтийн шаардлага хангасан, бакалаврын үндсэн хөтөлбөрт элсэн суралцагч бол элсэх мэргэжлийн хичээлийн элсэлтийн шалгалтад 600, түүнээс дээш оноо авсан, үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улирлын голч дүн 3.0-аас доошгүй байх;

5.5.3.магистрын үндсэн хөтөлбөрт элсэн суралцагч бол тухайн мэргэжлийн бакалаврын зэрэгтэй, мэргэжлээрээ 2-оос доошгүй жил ажилласан, өмнөх боловсролын зэргийн дипломын голч дүн 3.0-аас доошгүй, үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улирлын голч дүн 3.0-аас доошгүй байх;

5.5.4.докторын үндсэн хөтөлбөрт элсэн суралцагч бол тухайн мэргэжлийн магистрын зэрэгтэй, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан, судалгаа шинжилгээний ажлын бүтээл нийтлүүлсэн, өмнөх боловсролын зэргийн дипломын голч дүн 3.2-оос доошгүй, үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улирлын голч дүн 3.2-оос доошгүй байх.

5.6.Энэ журмын 5.3.2-т заасан гадаадын сургалтын байгууллагад суралцагч энэ журмын 2.2-т заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлага хангасан байна:

5.6.1.магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан байх;

5.6.2.үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улирлын голч дүн авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй байх.

5.7.Энэ журмын 5.3.3-т заасан техникийн боловсролын сургалтын байгууллагын олон улсын хөтөлбөрийг дотоодын сургуульд төгсөж, тухайн мэргэжлийн чиглэлээр гадаадын сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрөөр дэвшин суралцагч энэ журмын 2.2-т заасан нийтлэг шаардлагаас гадна тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийн чиглэлээр суралцагч байх тусгай шаардлагыг хангасан байна.



5.8.Энэ журмын 5.3.1-д заасан суралцагчид нэр дэвшүүлэх албан хаагчийг тухайн байгууллага дотроо нээлттэй зарлан, ил тод сонгон шалгаруулах бөгөөд холбогдох мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, сум, дүүргийн Засаг даргын тамгын газар нь аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлнэ.

5.9.Салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь энэ журмын 5.8-д заасан тэтгэлэгт хамрагдах нэр дэвшигчдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, тэнцсэн нэр дэвшигчийн мэдээллийг тухайн жилийн 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

5.10.Энэ журмын 5.3.1-д заасан суралцагчийг сонгон шалгаруулах, суралцах сургалтын байгууллагыг тодорхойлох, гэрээ байгуулахтай холбогдох үйл ажиллагааг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар зохион байгуулж, энэ журмын 1.8-д заасан хяналтын тоонд багтаан тэтгэлэгт хамрагдах албан хаагчийн мэдээллийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

5.11.Энэ журмын 5.10-д заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлсэн тэтгэлгээр суралцуулах төрийн албан хаагчдын нэрсийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр баталгаажуулж, санд хүргүүлнэ.

5.12.Сан энэ журмын 5.3.1-д заасан төрийн албан хаагчтай (захиалагч төрийн байгууллагыг оролцуулан) гурван талт гэрээ, 5.3.2, 5.3.3-т заасан суралцагчтай хоёр талт гэрээ байгуулна.

5.13.Энэ журмын 5.3.1, 5.3.3-т заасан суралцагчид сургалтын төлбөр, дотуур байрны зардал, 5.3.2-т заасан суралцагчид сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.

5.14.Энэ журмын 5.3.3-т заасан үргэлжлүүлэн тэтгэлгээр суралцагч нь дараагийн улиралд дэвшин суралцах эрхээ авсан бол, 5.3.1, 5.3.2-т заасан үргэлжлүүлэн тэтгэлгээр суралцагчийн өмнөх улиралд авсан голч дүн тухайн сургалтын байгууллагын үнэлгээний 75 хувиас доошгүй оноо авсан тохиолдолд тэтгэлгийн санхүүжилтийг үргэлжлүүлэн олгоно.

5.15.Төрийн албан хаагчийг төгссөний дараа захиалга өгсөн төрийн байгууллага өөрчлөн байгуулагдсан (нийлүүлэх, нэгтгэх, хуваах,

тусгаарлах, өөрчлөх хэлбэрээр), эсхүл зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн боловч түүний албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг хэвээр хадгалагдан үлдсэн бол албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулах, хэрэв тухайн чиг үүргийг хэрэгжүүлэх албан тушаал (ажлын байр)-ын орон тоо хасагдсан зэрэг шалтгаанаар урьд ажиллаж байсан албан тушаалд үргэлжлүүлэн ажиллуулах боломжгүй тохиолдолд төрийн албан хаагчтай тохиролцон өмнөх нөхцөлийг дордуулахгүйгээр өөр албан тушаалд томилогдон ажиллуулна.

Зургаа.Засгийн газар хоорондын тэтгэлэг

6.1.Монгол Улсаас гадаад улсад суралцах суралцагч энэ журмын 1.5-д заасан гэрээнд өөрөөр заагаагүй бол энэ журмын 2.2-т заасан нийтлэг шаардлагыг хангасан байна.

6.2.Сан Монгол Улсаас гадаад улсад суралцагчтай, гадаад улсаас Монгол Улсад суралцагчтай хоёр талт гэрээ байгуулна.

6.3.Монгол Улсаас гадаад улсад суралцах суралцагчид энэ журмын 1.5-д зааснаар, эсхүл энэ журмын 1.6-д заасны дагуу баталсан хэмжээгээр амьжиргааны зардлын тэтгэлэг олгоно.

6.4.Гадаад улсаас Монгол Улсад суралцах суралцагчийн талаар тухайн улстай харилцан адил байх зарчмыг баримтлах бөгөөд тэтгэлгийн хувьд сургалтын төлбөрийн болон дотуур байрны зардлыг тухайн сургалтын байгууллагын нэхэмжилсэн дүнгээр, хүнсний зардлыг Үндэсний статистикийн хорооноос тогтоосон тухайн жилийн хүн амын амьжиргааны доод түвшнээр тооцож олгоно.

6.5.Энэ журамд заасан тэтгэлгээр үргэлжлүүлэн суралцах тохиолдолд өмнөх улирлын голч дүн нь Монгол Улсаас гадаад улсад суралцагч бол авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй, гадаад улсаас Монгол Улсад суралцагч бол 2.0-оос доошгүй байна.

Долоо.Зарим эрэлттэй мэргэжлийн тэтгэлэг

7.1.Монгол Улсын нийгмийн салбарт хомсдолтой байгаа зарим мэргэжлийн чиглэлээр дотоодын болон гадаадын сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах суралцагчид тэтгэлэг олгоно.

7.2.Дотоодын сургалтын байгууллагад зарим эрэлттэй мэргэжлээр суралцагчид олгох тэтгэлэг дараах төрөлтэй байна:



7.2.1.сувилахуй, нийгмийн ажилтан, номын сан, хоол зүй, шим судлал мэргэжлийн үндсэн хөтөлбөрөөр суралцагчид олгох тэтгэлэг;

7.2.2.малчнаар 10-аас доошгүй жил тасралтгүй ажилласан малчны нэг хүүхдийг мал аж ахуй, тэжээл, бэлчээр судлалын чиглэлийн мэргэжил эзэмшүүлэх зорилгоор төрийн өмчийн сургалтын байгууллагын суралцагчид олгох тэтгэлэг;

7.2.3.бусад мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн, багшийн хөтөлбөрөөр суралцаж байгаа бол суралцагчид олгох тэтгэлэг;

7.2.4.хөгжлийн бэрхшээлтэй иргэнд чиглэсэн хэл засал, хөдөлгөөн засал, хөдөлмөр засал, сэтгэл зүй, арга зүй (эрүүл мэндийн, спортын)-н мэргэжлийн үндсэн хөтөлбөрөөр суралцагчид олгох.

7.3.Энэ журмын 7.2.4-т заасан мэргэжлээр гадаадын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрт суралцагчид тэтгэлэг олгож болно.

7.4.Энэ журмын 7.2.4-т заасан мэргэжлээр иргэн нь дотоодод дэд бакалавр болон бакалаврын үндсэн хөтөлбөрөөр хоёр дахь удаагаа суралцаж болно.

7.5.Энэ журмын 7.2.4-т заасан мэргэжлээр суралцагчид энэ журмын 2.1.5, 2.2.3-т заасан шаардлага хамаарахгүй.

7.6.Суралцагч энэ журмын 2.1, 2.2-т заасан нийтлэг шаардлагаас гадна төгссөнөөс хойш орон нутгийн байгууллагад 3 жил, нийслэлд 5 жил мэргэжлээрээ тогтвортой ажиллах нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн байна.

7.7.Дотоодын сургалтын байгууллагад элсэн суралцагч бол элсэлтийн шалгалтад тухайн мэргэжлийн чиглэлийн шалгалтад 501-ээс дээш оноо авсан тохиолдолд 100 хувийн, үргэлжлүүлэн суралцагч бол өмнөх улиралд 3.0, түүнээс дээш голч дүнтэй суралцсан тохиолдолд 100 хувийн, 2.8-3.0 хүртэл голч дүнтэй суралцсан тохиолдолд 70 хувийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгоно.

7.8.Гадаадын сургалтын байгууллагад үргэлжлүүлэн суралцагчийн өмнөх улирлын голч дүн авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй байх тохиолдолд сургалтын төлбөр, дотуур байрны төлбөрийн тэтгэлгийг олгоно.

7.9.Сан дотоодын сургалтын байгууллагад суралцагч болон сургалтын байгууллагатай гурван талт гэрээ, гадаадын сургалтын байгууллагад суралцагчтай хоёр талт гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулна.

Найм.Зорилтот бүлгийн суралцагчид олгох буцалтгүй тусламж

8.1.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.5-3.1.7-д заасан суралцагч (цаашид “зорилтот бүлгийн суралцагч” гэх)-д дотоодын сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцахад буцалтгүй тусламж олгоно.

8.2.Зорилтот бүлэгт дараах суралцагч хамаарна:

8.2.1.бүтэн өнчин суралцагч;

8.2.2.нэг гишүүн нь хөгжлийн бэрхшээлтэй өрхийн хагас өнчин суралцагч;

8.2.3.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч;

8.2.4.эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй өрхийн нэг суралцагч;

8.2.5.хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн нэг суралцагч;

8.2.6.цаатан, тува, урианхай үндэстний өрхийн нэг суралцагч;

8.2.7.нэг гэр бүлийн 3 болон түүнээс дээш хүүхэд дотоодын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрөөр зэрэг суралцаж байгаа бол нэг суралцагч.

8.3.Буцалтгүй тусламжаар үргэлжлүүлэн суралцах зорилтот бүлгийн суралцагчийн өмнөх улирлын голч дүн 2.0 буюу түүнээс дээш, эсхүл энэ журмын 8.2.3-т заасан хөгжлийн бэрхшээлтэй суралцагч дэвшин суралцах эрхээ авсан бол буцалтгүй тусламж олгоно.

8.4.Энэ журмын 8.2.3-т заасан суралцагчид Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15.6-д заасны дагуу дотоод, гадаадын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн болон техникийн боловсролын байгууллагад элсэн суралцах эрх авсан бол дараах буцалтгүй тусламжийг олгоно:

8.4.1.дотоодын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөр, дотуур байрны зардал;



8.4.2.гадаадын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөр, амьжиргааны зардал.

8.5.Сан дотоодын сургалтын байгууллагад суралцагч болон сургалтын байгууллагатай гурван талт гэрээг, гадаадын сургалтын байгууллагад суралцагчтай хоёр талт гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулна.

8.6.Энэ журмын 2.1.2-т заасан шаардлага дээрх 8.2-т заасан суралцагчид хамаарахгүй.

8.7.Дээрх 8.2.3-т заасан суралцагчид журмын 2.1.4, 2.1.5, 2.1.6, 2.2.2, 2.2.3, 2.2.4-т заасан шаардлага хамаарахгүй.

Ес.Сургалтын төлбөрийн хөнгөлөлт

9.1.Орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцах суралцагчид сургалтын төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээний хөнгөлөлт үзүүлнэ.

9.2.Суралцагч энэ журмын 2.1-д заасан нийтлэг шаардлага болон дараах тусгай шаардлага хангасан байна:

9.2.1.элсэн суралцагч дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэлтийн босго оноонд хүрсэн байх, магистр, докторын хөтөлбөрт суралцах бол өмнөх боловсролын зэргийн дипломын голч дүн 2.8-аас доошгүй байх;

9.2.2.дэд бакалавр, бакалаврын үндсэн хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцах суралцагчийн өмнөх улирлын голч дүн 2.8-аас доошгүй, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцагчийн голч дүн 3.0-аас доошгүй байх;

9.2.3.Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т заасан нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн байх.

9.3.Сан суралцагч болон сургалтын байгууллагатай холбогдох хууль тогтоомжийн дагуу гурван талт гэрээ байгуулна.

Арав.Сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл

10.1.Дотоод, гадаадын сургалтын байгууллагад бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр, мөн дотоодын сургалтын байгууллагад

дэд бакалавр хөтөлбөрөөр суралцах иргэнд сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээл олгоно.

10.2.Дотоодын сургалтын байгууллагад суралцагч энэ журмын 2.1-д заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан байна:

10.2.1. магадлан итгэмжлэгдсэн сургалтын байгууллагад дэд бакалавр, бакалавр, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцдаг байх;

10.2.2. элсэн суралцагч дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэлтийн босго оноонд хүрсэн, магистр, докторын хөтөлбөрт суралцах бол өмнөх боловсролын зэргийн дипломын голч дүн 2.8-аас доошгүй байх;

10.2.3. дэд бакалавр, бакалаврын үндсэн хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцагчийн өмнөх улирлын голч дүн 2.8-аас доошгүй, магистр, докторын үндсэн хөтөлбөрөөр суралцагчийн голч дүн 3.0-аас доошгүй байх;

10.2.4. Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасны дагуу “Өрийн мэдээллийн нэгдсэн сан”-д зээлийн үлдэгдэлгүй байх.

10.3. Дараах иргэн гадаадын сургалтын байгууллагад суралцах сургалтын төлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдана:

10.3.1. “2+2 хөтөлбөр”-ийн хүрээнд дотоодын сургалтын байгууллагад эхний хоёр жил амжилттай суралцаж, гадаадын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрөөр үргэлжлүүлэн суралцах эрх авсан суралцагч;

10.3.2. бакалаврын үндсэн хөтөлбөрөөр суралцах эрх авсан суралцагч;

10.3.3. гадаадын сургалтын байгууллагад магистр, докторт суралцагч.

10.4. Гадаадын сургалтын байгууллагад суралцагч энэ журмын 2.2-т заасан нийтлэг шаардлагаас гадна дараах тусгай шаардлагыг хангасан байна:

10.4.1. дэлхийн шилдэг их сургуулиудын зэрэглэл тогтоодог олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн “Таймс Хайэр Эдүкейшн Вөрлд



Юниверсити Ранкингс”-аас тухайн жилд тогтоосон эхний 100-д багтсан сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан байх;

10.4.2.энэ журмын 10.4.1-д заасан эрэмбийн жагсаалтын эхний 20-д багтсан сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол мэргэжил харгалзахгүй, 21-100-д багтсан сургалтын байгууллагад үндсэн хөтөлбөрөөр суралцах урилга авсан бол тэргүүлэх, эсхүл эрэлттэй мэргэжлийг сонгосон байх.

10.5.Үргэлжлүүлэн зээлээр суралцагчийн өмнөх улиралд авсан голч дүн тухайн сургалтын байгууллагын үнэлгээний 75 хувиас доошгүй оноо авсан тохиолдолд зээлийн санхүүжилтийг үргэлжлүүлэн олгоно.

10.6.Сан дотоодын сургалтын байгууллагад суралцагч болон сургалтын байгууллагатай гурван талт гэрээ, гадаадын сургалтын байгууллагад суралцагчтай хоёр талт гэрээ байгуулна.

10.7.Зээлийг энэ журмын 10.2-т заасан суралцагчид сургалтын төлбөрийн хэмжээгээр, 10.3-т заасан суралцагчид авсан тэтгэлгийн хэмжээг харгалзан сургалтын төлбөрийн үлдэх дүнгээр эргэн төлөх нөхцөлтэйгөөр олгоно.

10.8.Дотоодын сургалтын байгууллагад суралцагчид олгох зээл барьцаагүй, гадаадын сургалтын байгууллагад суралцагчид олгох зээлд үл хөдлөх эд хөрөнгө (цаашид “барьцааны зүйл” гэх) барьцаална.

10.9.Төгсөгч нь гэрээний дагуу энэ журмын 12.1.8-д заасан хугацаанд өөрөө, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан санд бүртгүүлнэ.

10.10.Сангаас энэ журмын 11.14.8-д заасны дагуу баталсан зээлийн эргэн төлөлтийн хуваарийг төгсөгч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид гэрээнд заасан хаягаар цахимаар болон монгол шуудангаар илгээснээр зээл төлөх хугацаа тоологдож эхэлнэ.

10.11.Дараах тохиолдолд зээл олгохгүй:

10.11.1.үл хөдлөх эд хөрөнгө зээлийн барьцааны шаардлага хангаагүй;

10.11.2.сангаас өмнө авсан зээл төлөөгүй;

10.11.3.энэ журмын 10.11.2-т зааснаас бусад гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

10.11.4.баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдсон.

10.12.Зээлээр үргэлжлүүлэн суралцах тохиолдолд өмнөх улирлын голч дүн дотоодын сургалтын байгууллагад суралцагч бол 2.8-аас доошгүй, гадаадын сургалтын байгууллагад суралцагч бол авбал зохих үнэлгээний 75 хувиас доошгүй байна.

10.13.Энэ журмын 2.1.2-т заасан шаардлага дотоодын сургалтын байгууллагад суралцагчид хамаарахгүй.

**Арван нэг.Гэрээ байгуулах, сунгах, түдгэлзүүлэх,
дуусгавар болгох**

11.1.Сан нь суралцагчтай холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулна. Суралцагчтай байгуулах гэрээний загварыг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

11.2.Суралцагчтай байгуулах гэрээг хичээлийн улирлын үргэлжлэх хугацаагаар байгуулах бөгөөд гэрээнд дараах зүйлийг тусгана:

11.2.1.суралцах боловсролын зэрэг, хугацаа;

11.2.2.зээл, тэтгэлэг, хөнгөлөлт, буцалтгүй тусламжийн хэмжээ;

11.2.3.оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага;

11.2.4.гэрээ түдгэлзүүлэх, сунгах, дуусгавар болгох нөхцөл;

11.2.5.зээлийн барьцаа, эргэн төлөлт;

11.2.6.бусад.

11.3.Суралцагчид зээл, тэтгэлэг, хөнгөлөлт, буцалтгүй тусламжийг олгохдоо дараах зохицуулалтыг баримтална:

11.3.1.тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжийг гэрээнд заасан зориулалт, хэмжээгээр олгоно;

11.3.2.гадаадын сургалтын байгууллагад суралцагчтай байгуулах гэрээнд олгох санхүүжилтийн дүнг тухайн улсын мөнгөн



тэмдэгтээр тусгаж, санхүүжилтийн эрх хүссэн өдрийн Монголбанкны валютын ханшийг баримталж олгоно;

11.3.3.сургалтын төлбөрийг сургалтын байгууллагын дансанд, дотуур байрны зардлыг холбогдох байгууллагын дансанд, хүнсний зардлыг суралцагчийн дансанд шилжүүлнэ.

11.4.Энэ журмын 11.3.3-т заасны дагуу шилжүүлэг хийхдээ холбогдох байгууллагаас ирүүлсэн албан ёсны баримтыг үндэслэнэ. Шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл, тодруулга авна.

11.5.Суралцагч гэрээнд заасны дагуу сурлагын дүн болон холбогдох мэдээллийг хичээлийн жилийн улирал бүр, сангаас шаардсан бусад мэдээллийг тухай бүр цахимаар санд хүргүүлнэ.

11.6.Дахин судалсан хичээлийн багц цагийн төлбөрийг суралцагч өөрөө хариуцна.

11.7.Суралцагч аливаа гэнэтийн осол, гэмтлийн улмаас амь насаа алдах, эрүүл мэндэд нь хохирол учрах, хөдөлмөрийн чадвар алдах, тооцоолоогүй санхүүгийн эрсдэлд орохоос хамгаалах зорилгоор эрсдэлийн даатгалд даатгуулсан байна.

11.8.Сан суралцагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, гэрээг дүгнэсэн баримтыг хавсаргах бөгөөд дараах шаардлага хангасан тохиолдолд гэрээг улирал тутам сунгана:

11.8.1.суралцагч сурлагын дүнгийн шаардлага хангасан байх;

11.8.2.гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлсэн байх.

11.9.Дараах тохиолдолд суралцагчид олгох санхүүжилтийг зогсоож, гэрээг 1 жил хүртэлх хугацаагаар түдгэлзүүлнэ:

11.9.1.суралцагч жирэмсний, амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй, эсхүл хүндэтгэн үзэх бусад шалтгааны улмаас нэг сараас дээш хугацаагаар суралцах боломжгүй болсныг эрх бүхий байгууллагын шийдвэрээр нотолсон бол;

11.9.2.энэ журмын 11.9.1-д заасан үндэслэлээр суралцах хугацааг түдгэлзүүлэхэд баримт үйлдэж, гэрээнд хавсаргана;

11.9.3.суралцагч холбогдох этгээдийн зөвшөөрснөөр өөр сургалтын байгууллагад шилжин суралцсан, гэрээнд заасан суралцах боловсролын зэрэг, мэргэжлийн чиглэлийг өөрчилсөн бол;

11.9.4.суралцагч сурлагын дүнгийн шаардлага хангаагүй бол.

11.10.Гэрээг түдгэлзүүлсэн хугацаанд тухайн суралцагчид тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламж олгохгүй.

11.11.Дараах үндэслэлээр гэрээг дуусгавар болгох шийдвэрийг сангийн Ажлын албаны даргын тушаалаар хагас жил тутамд баталгаажуулна:

11.11.1.гэрээний хугацаа дуусаж, талууд хүлээсэн үүргээ биелүүлсэн бол;

11.11.2.суралцагч нь нас барсан, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүй гэж шүүхээс тооцсон, хөдөлмөрийн чадвараа алдсаныг Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр тогтоосны дагуу барьцааны зүйлээр болон даатгалын гэрээнд заасны дагуу гэрээний үүргийн гүйцэтгэл хангасан;

11.11.3.барьцааны зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулж, гэрээний үүргийн гүйцэтгэл хангагдсан.

11.12.Аль нэг талын санаачилгаар хугацаа дуусахаас өмнө гэрээг дараах тохиолдолд цуцална:

11.12.1.суралцагч өөр сургалтын байгууллагад шилжин суралцсан, гэрээнд заасан суралцах мэргэжлийн чиглэлийг өөрчилсөн;

11.12.2.суралцагч сургалтын байгууллагаас хасагдсан, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сургуулиа орхисон, чөлөө авсан, чөлөөний хугацааг сунгасан;

11.12.3.тэтгэлэг, хөнгөлөлтөөр суралцагч төгсөөд жирэмсний, амаржсаны амралттай, хүүхэд асрах чөлөөтэй болон хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд 12 сарын хугацаанд ажилд ороогүй, эсхүл гэрээнд заасны дагуу ажиллаагүй;

11.12.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлгээр суралцагч аймаг (сумаас шалгарсан бол), нийслэлд (хорооноос шалгарсан бол) мэргэжлийн ажил санал болгоход өөрийн хүсэлтээр татгалзсан;

11.12.5.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрт суралцагч бэлтгэл хөтөлбөрийг төгсөөд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гадаад улсад суралцахаас татгалзсан, эсхүл татгалзсан тухайгаа мэдэгдээгүй;



11.12.6.суралцагч хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

11.12.7.суралцах хугацаандаа гэмт хэрэгт холбогдож, гэм буруутайг нь шүүхээс тогтоосон.

11.13.Энэ журмын 11.11, 11.12-т заасан үндэслэлээр гэрээ дуусгавар болгох, эсхүл цуцлахад талууд гэрээ дүгнэсэн баримт үйлдэнэ.

11.14.Гэрээнд заасан барьцаа болон зээлийн эргэн төлөлтөд дараах зохицуулалтыг баримтална:

11.14.1.суралцагч барьцааны зүйлийн үнэлгээг эрх бүхий хуулийн этгээдээр хийлгэсэн байх бөгөөд барьцааны зүйлийн үнэлгээ суралцагчийн авах нийт зээлийн үнийн дүнгийн 50 хувиас доошгүй байна;

11.14.2.барьцааны зүйл суралцагчийн, эсхүл хамаарал бүхий гуравдагч этгээдийн өмчлөлд байх бөгөөд барьцааны зүйлийн талаар улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас лавлагаа авсан байна;

11.14.3.суралцагч барьцааны гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлж, сан барьцаа бүртгэсэн талаарх лавлагааг суралцагчийн хувийн хэрэгт хавсаргана;

11.14.4.суралцагч барьцааны зүйлийг даатгуулсан байна;

11.14.5.зээлийн эргэн төлөлтийн хуваарийг олгосон санхүүжилтийн дүнгээр гаргана;

11.14.6.энэ журмын 12.1.8-д заасныг үндэслэн сан эргэн төлөлтийн хуваарийг үүсгэж, сургууль төгсөгчид, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгчид энэ тухай мэдэгдэнэ;

11.14.7.суралцагчийн зээлийн эргэн төлөлтийн хуваарийг сан үүсгэн батлах бөгөөд дотоодын сургалтын байгууллагад суралцагч 5 хүртэлх жилийн дотор, гадаадын сургалтын байгууллагад суралцагч 20 хүртэлх жилийн дотор сургууль төгссөнөөс хойш 6 сарын дараагаас эхлэн эргэн төлнө;

11.14.8.зээлдэгч зээлийн эргэн төлөлтийг гэрээнд заасан хуваарийн дагуу сангийн дансанд шилжүүлнэ.

11.14.9.гэрээг энэ журмын 11.12-т заасны дагуу цуцалсан тохиолдолд сангаас тухайн иргэнд олгосон санхүүжилтийг 2 жилийн дотор бүрэн буцаан төлнө;

11.14.10.олгосон санхүүжилтийг эргэн төлүүлэхэд нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу валютын ханшийг тооцно.

11.15.Зээлийн эргэн төлөх хугацааг энэ журмын 11.9.1-д заасан хүндэтгэн үзэх шалтгаанаар орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагч 2 жил, гадаадын сургалтын байгууллагад зээлээр суралцагч 5 хүртэлх жилээр нэг удаа сунгаж болно.

11.16.Энэ журамд заасан суралцагч төгсөөд ажилласан байх хугацааны шаардлагыг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн баримтаар баталгаажуулна. Сайн дурын даатгалын төлөлт гэрээнд заасан ажилласан хугацаанд хамаарахгүй.

11.17.Төгсөгчийн ажиллаж байгаа байгууллага өөрчлөн байгуулагдсан (нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх), зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөн, татан буугдсан, эсхүл өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар албан тушаалын орон тоо хасагдсаны улмаас өөр ажил, албан тушаалд сэлгэн ажиллах тохиолдолд өмнө ажилласан хугацааг ажилласан хугацаанд оруулан тооцно.

11.18.Төгсөгч суралцсан мэргэжлээрээ гадаадад туршлага хуримтлуулах зорилгоор 3 хүртэлх жил ажиллаж болох бөгөөд энэ нь зээлийн эргэн төлөлтийн хугацаанд өөрчлөлт оруулах үндэслэл болохгүй.

**Арван хоёр.Суралцагч, сургалтын байгууллага,
сангийн эрх, үүрэг**

12.1.Суралцагч дараах эрх, үүрэгтэй байна:

12.1.1.тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжийн хүсэлт гаргах;

12.1.2.өргөдөл, гомдол гаргах;

12.1.3.гэрээний үүргээ биелүүлэхийг сан болон сургалтын байгууллагаас шаардах;

12.1.4.энэ журамд заасан баримт бичгийг бүрэн бүрдүүлэх;



12.1.5.суралцагчаас үл хамаарсан шалтгаанаар суралцаж байгаа мэргэжлийн чиглэл өөрчлөгдсөнөөс бусад тохиолдолд сургалтын байгууллага хооронд шилжихгүйгээр сонгосон мэргэжлээр суралцах;

12.1.6.гэрээний биелэлтийг дүгнэхэд санг шаардлагатай мэдээллээр хангах;

12.1.7.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

12.1.8.гадаадын сургалтын байгууллагад тэтгэлгээр суралцагч төгсөөд дипломоо хүлээн авсан өдрөөс хойш 2 сарын дотор өөрийн биеэр санд бүртгүүлэх;

12.1.9.тэтгэлэг, хөнгөлөлтөөр суралцагч төгсөөд 1 жилийн дотор ажилд орох;

12.1.10.энэ журамд өөрөөр заагаагүй бол дотоодын сургалтын байгууллагад тэтгэлэг, хөнгөлөлтөөр суралцагч төгсөөд мэргэжлээрээ 3-5 жил, гадаадын сургалтын байгууллагад тэтгэлгээр суралцагч төгсөөд эх орондоо, мэргэжил заасан бол мэргэжлээрээ 5-аас доошгүй жил гэрээнд заасны дагуу ажиллах;

12.1.11.тэтгэлгээр суралцагч гэрээний хугацаанд сургуулиа төгсөж чадаагүй тохиолдолд энэ журмын 11.9.1-д заасан хүндэтгэн үзэх шалтгаанаас бусад тохиолдолд сангаас олгосон санхүүжилтийг буцаан төлнө.

12.2.Дотоодын сургалтын байгууллага дараах эрх, үүрэгтэй байна:

12.2.1.суралцагчид олгох тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламжийн талаарх тайлбар, мэдээллийг сангаас авах;

12.2.2.тогтоосон хугацаанд санхүүжилт шилжүүлэхийг сангаас шаардах;

12.2.3.сан болон суралцагчаас гэрээний үүргээ биелүүлэхийг шаардах;

12.2.4.суралцагч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах саналаа санд хүргүүлэх;

12.2.5.суралцагчийн тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламж хүссэн хүсэлтийг хүлээн авах, хянах, санд уламжлах, энэ талаар суралцагчид мэдэгдэх;

12.2.6.хяналтын тоонд багтсан суралцагчийн мэдээллийг төрөлжсөн сангийн нэгдсэн системд бүртгэх, суралцагчийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг тухай бүр шинэчлэх;

12.2.7.суралцагчийн голч дүн болон бусад мэдээллийг удирдлага мэдээллийн системд бүртгэх, улирал тутам шинэчлэх, олон нийтэд ил тод байршуулах;

12.2.8.гэрээний биелэлтийг дүгнэхэд болон бусад шаардлагатай мэдээллийг санд гаргаж өгөх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх;

12.2.9.гэрээний хэрэгжилтийг хангуулах, биелэлтэд хяналт тавих;

12.2.10.гэрээний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 06 болон 12 дугаар сарын сүүлийн 7 хоногт санд хүргүүлэх.

12.3.Сан дараах эрх, үүрэгтэй байна:

12.3.1.дотоодын сургалтын байгууллагаас ирүүлсэн хүсэлт, баримт бичгийг хүлээн авах, хянах, шаардлага хангаагүй суралцагчийг хасах;

12.3.2.суралцагчтай гэрээ байгуулах, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, дуусгавар болгох;

12.3.3.санхүүжилтийг гэрээнд заасны дагуу шилжүүлэх;

12.3.4.гэрээний үүргээ биелүүлэхийг суралцагч болон сургалтын байгууллагаас шаардах;

12.3.5.гэрээний биелэлтэд хяналт тавих, улирал тутам үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангуулах;

12.3.6.гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулан санхүүжилтийг зогсоох, суутгах, эргэн төлүүлэх;

12.3.7.санхүүжилтийн зарцуулалтын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

12.3.8.энэ журмын 13.2-т заасан мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, олон нийтэд ил тод байршуулах.



Арван гурав.Бусад

13.1.Энэ журмын хэрэгжилтэд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.

13.2.Сан сонгон шалгаруулалт, гэрээний биелэлтийн ил тод байдлыг хангах зорилгоор мэдээллийн нэгдсэн санг үүсгэнэ.

13.3.Сан тэтгэлэг, зээл, хөнгөлөлт, буцалтгүй тусламж тус бүрээр суралцагч, төгсөгчийн мэдээллийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн дагуу олон нийтэд мэдээлнэ.

13.4.Сан тухайн жилд байгуулсан, түдгэлзүүлсэн, сунгасан, цуцалсан, дуусгавар болсон гэрээний талаар дараа жилийн I улиралд багтаан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

13.5.Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газраас энэ журмын дагуу гадаадад суралцагчид тухайн улс дахь соёл, зан заншил, дотуур байрны талаар шаардлагатай зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлнэ. Тухайн улсад тэтгэлгээр суралцагчийн сурлагын явцын талаарх судалгаа, холбогдох мэдээлэл (сурлагын дүн, ёс зүй, санхүүжилт)-ийг хичээлийн жилийн улирал бүр санд хүргүүлнэ.

13.6.Сан суралцагчийн хувийн хэрэг (анкет, иргэний үнэмлэхийн хуулбар, сургалтын байгууллагын урилга, гадаад хэлний шалгалтын материал, онооны хуудас, гэрээ, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний тайлан, гэрчилгээний хуулбар, барьцаа бүртгэсэн талаарх лавлагаа, дипломын хуулбар болон бусад)-ийг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу цаасаар болон цахимаар хадгална.

13.7.Зээлдэгчийн асуудлаар хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, зээлдэгчийн мэдээллийг буруу гаргаж ирүүлсэн нь хууль, хяналтын байгууллагаар тогтоогдвол сургуулийн удирдлага, албан тушаалтанд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

13.8.Гэрээ байгуулах, түдгэлзүүлэх, сунгах, дуусгавар болгохтой холбоотой энэ журамд заагаагүй бусад асуудлыг Иргэний хуульд заасны дагуу зохицуулна.

13.9.Энэ журамд заасан үүргээ зөрчсөн эрх бүхий албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль болон гэрээнд заасан хариуцлага хүлээлгэнэ.

13.10.Энэ журам болон зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ зээлдэгч биелүүлээгүй, зээлийн гэрээтэй холбоотой маргаан үүссэн тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.

---o0o---



Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 4.75

Индекс: 200003